



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаартай “Эрх, үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 5 дугаар хавсралт, Нийслэл дэх Төрийн аудитын газрын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын /АГГ-2022/20-ШТА-ГА/ тайлан, акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангуулж, дүнг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хариу мэдэгдэхийг Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (Ж.Батбаясгалан), Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч (Д.Сумьяабазар), Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга (С.Нямдорж), Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (Л.Цолмонгэрэл), Багахангай дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (Д.Энхтайван), Багануур дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Ичинхорлоо), Баянгол дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (Г.Батбаяр), Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (Б.Энхтөгс), Хан-уул дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Амартүвшин), Сонгинохайрхан дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (П.Энхтуул), Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (М.Отгонтуяа), Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга (А.Сэрээтэр)-д тус тус зөвлөсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гаргаж танилцуулахыг Аудитын гуравдугаар хэлтэс (Э.Мөнхмандах)-т үүрэг болгосугай.

4. Тайланг Үндэсний аудитын газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


АУДИТЫН ТАЙЛАН

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар баримтлах бодлогын хэрэгжилт Нийслэл, дүүргийн түвшинд төлөвлөх, санхүүжүүлэх, тайлагнах, хянах, нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ хангалтгүйгээс үр дүн, үр ашиг муутай байна.



АУДИТЫН СЭДЭВ: ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Улаанбаатар хот
2022 он

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг	4-5
Нийслэл дэх Төрийн аудитын газар. Аудитын III хэлтэс	Хүснэгтийн жагсаалт	6-7
Хэлтсийн дарга, аудитын менежер	Хавсралтын жагсаалт	
 Э.Мөнхмандах	Графикийн жагсаалт	
Аудитын менежер	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	8
Б.Номинбаатар	Ерөнхий мэдээлэл	9
Аудитор	Бүлэг 1. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх?	10
 Д.Дайриймаа	А. 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай байна уу?	10-14
З.Баярбилэгт	А. 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн үү?	14-15
Б.Ууганбилэг	А.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна уу?	16-20
Хаяг: УБ хот, Сүхбаатар дүүрэг, Соёлын Төв өргөө Г корпус. Утас: 327787 Тайланг https://audit.mn/ веб сайтаас үзнэ үү.	Бүлэг 2. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байна уу?	21
	Б.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?	21-25
	Б.2. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна уу?	26-42
	Б.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан уу?	42-45
	Б.4. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн үү?	45

Б.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	45-48
Аудитын дүгнэлт	49
Аудитын зөвлөмж	50-51
Холбогдох байгууллагуудын санал	52-54
Саналд өгсөн тайлбар	55
Хавсралтууд	56-61

Товчилсон үг

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АБДХ	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМЗҮХХ	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөгжүүлэх хөтөлбөр
АМЧБО	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
АННБ	Аж ахуй нэгж байгууллага
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗХЭГБДХ	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
МБСДС	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан
МБСХБ	Мэргэжил боловсрол сургалт хөгжлийн байгууллага
МСҮТ	Мэргэжил сургалтын үндэсний төв
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МХЭДХ	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
НБХ	Нийгэм бодлогын хэлтэс
НД	Налайх дүүрэг
НЗД	Нийслэлийн засаг дарга
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НИТХТ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол
НОК	Нийслэлийн онцгой комисс
НҮТББ	Нийтлэг үйлчилгээний төрийн бус байгууллага
НХЭГ	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
НЭЗНХҮЧ	Нийслэлийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
НЭЗХҮЧ	Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл
ОУБ	Олон улсын байгууллага
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТХЭТБ	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын их хурал
УОК	Улсын онцгой комисс
ХАА	Хөдөө аж ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБИХЭДХ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
ХБХЭУЧОХ	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХҮХ	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс
ХЭ	Хөдөлмөр эрхлэлт
ХЭА	Хөдөлмөр эрхлэлтийн алба
ХЭД	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

ХЭДС
ХЭДТХ
ХЭСЗ
ХЭУЧ
ХЭҮЗ
ЦТҮААЭҮАСХ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар
Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх
хөтөлбөр

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хүснэгт 1	Хөтөлбөрүүдийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байдал	10-11
Хүснэгт 2	НИТХ-аас ХЭД чиглэлээр дэд хөтөлбөрт нийслэлийн төсвөөс баталсан, санхүүжилт	11-12
Хүснэгт 3	Нийслэл дүүргийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгаа 2016-2021 он	13
Хүснэгт 4	Орон нутагт бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	14
Хүснэгт 5	Нийслэл, дүүргүүдийн ХХҮХ-ээс төсвийн төсөлд тусгуулахаар өгсөн санал	15
Хүснэгт 6	ХЭДС-аас 2018-2019 онд хэрэгжсэн орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээний санхүүжилт	17
Хүснэгт 7	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	18-19
Хүснэгт 8	ХЭС3-ийн дүрмийн бус гишүүд	19
Хүснэгт 9	ХЭС3-ийн үйл ажиллагааны зардал 2016-2021	19-20
Хүснэгт 10	АМЧБО зөвлөгөө авах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016-2020 он	22
Хүснэгт 11	Зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016-2020 он	23
Хүснэгт 12	Мэдээллийн системийн ашиглалт	24
Хүснэгт 13	Нийслэл, дүүргийн ХХҮХ-ээс LMIS-д оруулсан мэдээлэл	24-25
Хүснэгт 14	Харьцуулсан судалгаа 2016-2021 он	25
Хүснэгт 15	ОУБ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр	27-28
Хүснэгт 16	Хөтөлбөрийн өөрчлөлт	30
Хүснэгт 17	АБДХ-ийн 2016-2021 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл	30
Хүснэгт 18	АБДХ-ийн 2016-2021 оны эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн зээлийн эргэн төлөлт, чанаргүй зээлийн үлдэгдэл	31
Хүснэгт 19	АМЗҮХХ-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэл, хэрэгжилт	33
Хүснэгт 20	2016-2020 оны нийслэлийн хэмжээний ХБИ-ний тоо	33
Хүснэгт 21	ХБИХЭДХ-т зарцуулсан хөрөнгө нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 он	34
Хүснэгт 22	ХЭҮЗ-өөс ХБИ-ний санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хийсэн өөрчлөлт	35
Хүснэгт 23	МХЭДХ-ийн гүйцэтгэл, хэрэгжилт 2016-2021	36
Хүснэгт 24	ЗХЭГБДХ-т зарцуулсан хөрөнгө, нийслэл дүүргийн хэмжээнд 2016-2021 он	37
Хүснэгт 25	ЗХЭГБДХ-ийн Старт-ап арга хэмжээнд олгох санхүүгийн дэмжлэгийн өөрчлөлт	38
Хүснэгт 26	ЗХЭГБДХ-т олгосон санхүүгийн дэмжлэгийн зээлийн эргэн төлөлт, чанаргүй зээлийн үлдэгдэл нийслэл дүүргийн хэмжээнд 2016-2021 он	38-39
Хүснэгт 27	ХБХЭУЧОХ-т зарцуулсан хөрөнгө, нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 он	39
Хүснэгт 28	НХЭГ-с ХЭУЧОХ-т хамрагдсан иргэдийн судалгаа	40
Хүснэгт 29	ЦТҮААЭҮАСХ-т зарцуулсан хөрөнгө, нийслэл, дүүргийн хэмжээнд 2021 он	41
Хүснэгт 30	Нийслэл, дүүрэгт хэрэгжсэн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хүйсийн байдал 2016-2021 он	41-42
Хүснэгт 31	ХЭДС-ийн санхүүжилт, зарцуулалт 2016-2021	43
Хүснэгт 32	2016-2021 онд ХЭДС-д төвлөрүүлсэн орлого	44
АГГ-2022/20-ШТА-ГА		6

Хүснэгт 33	Нийслэлд бүртгэлтэй ААНБ-ын тоог үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл	47
------------	--	----

Хавсралтын жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Хавсралт 1	НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилт, биелэлт	56
Хавсралт 2	НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-д 2016-2020 онд ОУБ-аас санхүүжсэн төсөл, арга хэмжээ	57-58
Хавсралт 3	Нийслэл, дүүргүүдийн ХЭСЗ-ийн дүрмийн хэрэгжилт 2016-2021	58-59
Хавсралт 4	Орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээнд олгосон зээлийн мэдээлэл	60-61

Дүрслэл, графикийн жагсаалт

Дугаар	Гарчиг	Хуудас
Дүрслэл 1	ХЭ-ийн байгууллагын тогтолцоо	16
Дүрслэл 2	АМЧБО зөвлөгөө өгөх зорилтот бүлгийн иргэд	21
Дүрслэл 3	АБДХ-ийн хэрэгжүүлэх арга хэмжээ	30
Дүрслэл 4	Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн нөхцөл	32
Дүрслэл 5	АМЗҮХХ-т хэрэгжүүлэх арга хэмжээ	32
Дүрслэл 6	ХБИХ-т хэрэгжүүлэх арга хэмжээ	34
Дүрслэл 7	ЗХЭГБДХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээ	37
Дүрслэл 8	Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ	38
Дүрслэл 9	ЦТҮААЭҮАСХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээ	41
График 1	АМЧБО харьцуулсан судалгаа	22
График 2	ХЭҮЗ-өөс батлагдаж нийслэл, дүүргүүдийн ХХҮХ-т батлагдан ирсэн хугацаа	29
График 3	Төсөл, хөтөлбөрийн төсөвт хөрөнгө	29
График 4	Нийт ХБИ-ийг хөтөлбөрт хамрагдсан иргэнтэй харьцуулсан харьцаа	35
График 5	ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлсөн төлбөр	44
График 6	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ийг салбар, дүүргээр нь авч үзсэн байдал	48

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газар болон Нийслэл дэх Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.
Аудитын хамарсан хүрээ	Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. А. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичиг, мөн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоо хангагдсан эсэх; Б. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалт үр ашигтай байгаа эсэх. Аудитад Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар, Нийслэлийн 9 дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, хөдөлмөр эрхлэлтийн алба, нийслэл, дүүргийн салбар зөвлөлийн 2016-2021 оны үйл ажиллагаа болон бусад холбогдох байгууллагын баримт материалыг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 300, 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх, газар дээр нь тулган баталгаажуулах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулан, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг аудитын гуравдугаар хэлтсийн дарга, аудитын менежер Э.Мөнхмандах удирдаж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Номинбаатар хэрэгжүүлж, Аудитор Д.Дайриймаа, З.Баярбилэгт, Б.Ууганбилэг нарын бүрэлдэхүүнтэйгээр 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс 5 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан.

Бодлогын баримт бичгийг зорилго нь “Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулахад чиглэнэ” гэж заасан.

Дээрх бодлогыг 2016-2026 онуудад 2¹ үе шатаар хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд бодлогын нэгдүгээр үе шат нь 2016-2020 онд хэрэгжиж дууссан байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсантай холбогдуулан “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”-ын баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 314 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон байна.

Бодлогын хэрэгжилтийг хангахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах төсөл, хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн байна. Үүнд:

№	2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2017-2020 онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ
3	Аж ахуй эрхлэх бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
8	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	-

Монгол Улсын Засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд 2016-2021 онд 919.3 тэрбум төгрөгийг зарцуулснаас хөдөлмөрийн эрхлэлтийн салбарын зардалд 349.9 тэрбум төгрөг буюу 38.1%-ийг, мэргэжлийн боловсролын зардалд 540.1 тэрбум төгрөг буюу 58.7%, хөдөлмөр эрхлэлтийн хөрөнгө оруулалтын зардалд 29.3 тэрбум төгрөг буюу 3.2%-ийг тус тус зарцуулсан байна.

Нийслэл болон 9 дүүргийн ХХҮХ-дэд 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн салбарын зардалд гарсан 349.9 тэрбум төгрөгөөс 51.7 тэрбум төгрөг буюу 14.7% батлагдаж ирснээс 44.5 тэрбум төгрөгийг зарцуулж 7.2 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗХҮЧ-д дээрх баримт бичиг болон төлөвлөгөөтэй уялдсан 9 чиглэл бүхий арга хэмжээг баталж, 2 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

¹ Нэгдүгээр үе шат: 2016 -2020 он;
Хоёрдугаар үе шат: 2021-2025 он.

А. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРГИЙН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАГДСАН ЭСЭХ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь хөгжлийн зорилт бодлого чиглэлтэй уялдсан хэдий ч төрийн байгууллагуудын бүтэц чиг үүрэг харилцан уялдаагүйгээс удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаагаа тайлагнах, хянах харилцаа хангалтгүй байна.

А.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь үндэсний урт болон дунд хугацааны тогтвортой хөгжлийн зорилттой уялдаатай байна уу?

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлэн Нийслэл, дүүрэгт хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь “Алсын хараа 2050”, “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2025”, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 болон 2020-2024” үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэл, дүүргийн засаг даргын 2016-2020 болон 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗХҮЧ-д тусгагдсан хүн амын хөгжил болон ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад чиглэсэн зорилтуудтай уялджээ.

1.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацааны бодлогыг орон нутагт хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн эсэх?

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хүрээнд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ажиллах хүчин бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 11 зорилт, НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт 9 зорилтыг дунд хугацаанд, “Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний зөвлөл”, Нийслэл, дүүргийн НЭЗХҮЧ болон төр захиргааны байгууллагуудын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээг жил бүр батлан богино хугацаанд хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Үүнд:

Хүснэгт №1 Хөтөлбөрүүдийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байдал

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого Нэгдүгээр үе шат 2016-2020	Батлагдсан хөтөлбөрүүд	НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	
		Заалтын дугаар, утга	
Хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4.7.3	Шинэ ажлын байр бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн ажил олгогчдыг дэмжих урамшууллын систем бий болгоно.
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	4.7.5	Нийслэлийн “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төв” байгуулж, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин, ажил олгогч, ажил хайгч иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлнэ.
	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	4.7.9	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэн, түр болон байнгын ажлын байраар хангана.

эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулахад чиглэнэ.	Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр	4.7.5	Оюутан залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Орлоготой оюутан” хөтөлбөр хэрэгжүүлж, суралцах хугацаандаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.
	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Тусгагдаагүй	
	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хөтөлбөр	4.7.5	Нийслэлийн “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төв” байгуулж, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин, ажил олгогч, ажил хайгч иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлнэ.
	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр	Тусгагдаагүй	

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗХҮЧ-д дээрх баримт бичгүүд болон төлөвлөгөөтэй уялдсан 5 чиглэл бүхий арга хэмжээг баталж, 2 арга хэмжээг дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгаагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9² дэх заалтад “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулж, батлуулахаар тусгажээ. Тус хуулийн хүрээнд Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020.12.04-ний 02/10 дугаар тогтоолын 2.4 дэх хэсэгт “Монгол улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд суурилсан Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж НИТХ-д өргөн мэдүүлэх”-ээр Нийслэлийн Засаг дарга-д даалгасан боловч “МУ-ын 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө” батлагдаагүй гэх шалтгаанаар “Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г боловсруулж, богино хугацааны бодлогын баримт бичгийг батлуулаагүй байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичгийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7³ дах заалтад заасны дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, НЭЗХҮЧ-д хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 9 арга хэмжээг баталснаас 7 арга хэмжээ биелэгдэж, 2 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйгээс 70%-ийн хэрэгжилттэй байна. Хавсралт №1

Мөн НИТХ-ын тогтоолоор нийслэлийн иргэдэд хөдөлмөр эрхлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2 дэд хөтөлбөрийн батлан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №2 НИТХ-аас ХЭД чиглэлээр дэд хөтөлбөрт нийслэлийн төсвөөс баталсан, санхүүжилт

	Хамрах хугацаа	Бодлогын баримт бичгийн нэр	Дэд хөтөлбөр	Санхүүжилт /сая.төг/	Дэд хөтөлбөр	Санхүүжилт /сая.төг/
1	2016	“Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 32/33 дугаар тогтоол	Бичил зээлийн сан	4,452.0	-	-
2	2017	“Нийслэлийн 2017 оны төсөв батлах тухай” 6/11 дугаар тогтоол	Бичил зээлийг дэмжих хөтөлбөр	11,094.1	“Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөрт	1,000.0

²Богино хугацааны буюу нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Аймаг, нийслэл хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, орон нутгийн төсөв хамаарна;

³Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

3	2018	“Нийслэлийн 2018 оны төсөв батлах тухай” 02/22 дугаар тогтоол	Бичил зээлийг дэмжих хөтөлбөр	14,409.9	“Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөрт	300.0
4	2019	“Нийслэлийн 2019 оны төсөв батлах тухай” 20/17 дугаар тогтоол	Бичил зээлийг дэмжих хөтөлбөр	4,269.1	“Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөрт	300.0
5	2020	“Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай” 29/31 дугаар тогтоол	Бичил зээлийг дэмжих хөтөлбөр	4,830.2	“Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөрт	500.0
6	2021	“Нийслэлийн 2021 оны төсөв батлах тухай” 02/1 дугаар тогтоол	Бичил зээлийг дэмжих арга хэмжээ	5,482.3	Бүх нийтийн бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ	500.0
НИЙТ				44,537.6		2,600.0

- “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах” дэд хөтөлбөр /2016-2021 онд хөтөлбөр, арга хэмжээний нэр өөрчлөгдсөн/

НИТХ-ын 2014 оны 17/16 дугаар тогтоолоор “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийг баталжээ. Хөтөлбөр 4 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 2014-2016 оны хооронд дэд хөтөлбөрийг нийслэлийн 152 хороонд хэрэгжүүлж, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан 123 хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулан 3479 төсөлд 14,307.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, шинээр 411 ажлын байр бий болж, 1720 ажлын байр хадгалагдаж үлдсэн үр дүнтэй байна. 2021 оны байдлаар 6,617.1 сая төгрөгийг эргэн төвлөрүүлж 7,690.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй, шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна.

- “Нэг өрх-нэг ажлын байр” дэд хөтөлбөр /2021 онд хөтөлбөр, арга хэмжээний нэр өөрчлөгдсөн/

НИТХ-ын 2017 оны 71 дүгээр тогтоолоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг НЗД-ын 2017 оны А/553 дугаар захирамжаар баталжээ. Хөтөлбөр нь 4 үндсэн зорилтын хүрээнд 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаснаас 11965 ажилгүй иргэнийг бүртгэж, 7422 иргэнийг тохирох ажлын байранд зуучилснаас 4040 иргэн ажлын байраар хангагджээ.

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх дунд, богино хугацаанд баримтлах бодлогын хэрэгжилт 87.6%-тай байна.

1.2 Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой судалгаанд үндэслэн тооцоолж байна уу?

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 2.1⁴-т зах зээлийн эрэлт хэрэгцээг бодитой тооцох чиглэлээр зорилт болгон тусгажээ.

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрэмд заасан “харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийт ажлын байр, шинээр бий болсон, байхгүй болсон сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээлэл цуглуулах, ХЭ-ийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх” чиг үүргийн хүрээнд дүүргүүдийн ХХҮХ-ээс зах зээлийн төлөв байдлын судалгааг сар тутам тайлагнаж НХЭГ-т нэгтгүүлдэг.

Энэ нь зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн бүртгэл мэдээллийн <http://lmis.gov.mn>-д бүртгэсэн хөтөлбөрт хамрагдсан иргэн, ААНБ-ын мэдээллийг нэгтгэн тайлагнадаг байна. Харин энэ мэдээллийг тухайн дүүрэг, хорооны

⁴ Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлж, ажиллах хүчний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэн зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ядуурлын түвшнийг бууруулахад чиглэнэ.

хөдөлмөрийн насны хүн амын тоотой харьцуулж, ажлын байр шаардлагатай иргэд буюу хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн нэгдсэн судалгаа байхгүй байна. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг өнөөгийн бодит байдалд тулгуурласан тооцоо судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай байна. Тухайлбал:

Хүснэгт №3 Нийслэл, дүүргийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын судалгаа 2016-2021 он /хүн.тоо/

Д/д	Нэрс	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НХЭГ	НИЙТ
1	Шинээр бий болсон ажлын байрны тоо	1172	307	4871	10658	1669	13190	6486	8484	4789	6856	58482
2	Ажлын байрны захиалгын тоо	2228	636	13491	14967	5875	17320	8872	11513	11465	57195	143562
3	Бүртгүүлсэн иргэдийн тоо	2722	1668	9460	24134	2589	21746	9913	19090	9692	41024	142038
4	Зуучилсан иргэдийн тоо	2991	564	11522	8847	3567	15393	6769	8374	7450	45406	110883
5	Үүнээс ажилд орсон иргэдийн тоо	1951	527	7319	3576	3844	13437	6342	5868	6848	29844	79556
6	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгосон иргэдийн тоо	5673	1454	16160	17527	5016	25482	12750	14313	16719	69766	184860
7	Нийтийг хамарсан ажилд хамрагдсан иргэдийн тоо	1936	1091	3013	5745	1806	4373	6430	4228	3560	3623	35805

Нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 онд нийт 58,482 ажлын байр шинээр бүртгэгдэж 143,562 ажлын байрны захиалга авч 142,038 ажилгүй иргэд бүртгэснээс 79,556 нь буюу 56% ажилд орж 184,860 иргэнд ажил мэргэжлийн зөвлөгөө өгсөн байна.

Дүгнэлт: Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлыг бүртгэж байгаа боловч эрэлт хэрэгцээг тооцох суурь судалгаагүй байна.

1.3 Орон нутагт бодлогын баримт бичгийг боловсруулахад бүх талуудын оролцоог хангасан уу?

ХБТТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.13⁵-т зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр нийслэл, дүүргийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөтөлбөрт тусгуулах саналыг НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ, ХЭА нь боловсруулж хүргүүлдэг байна.

НХЭГ-аас НЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2 дэд хөтөлбөр 7 арга хэмжээ, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2 арга хэмжээ 8 заалт, НЭЗХҮЧ-д тусгуулах саналыг тухай бүр өгч ажиллажээ.

Дүүргүүдийн ЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 6 дүүрэг санал өгч, 3 дүүрэг санал өгөөгүй. НЭЗХҮЧ-д 6 дүүрэг санал өгч, 3 дүүрэг санал өгөөгүй байна.

⁵.бүх талын оролцоог хангасан байх

Хүснэгт №4 Орон нутагт бодлогын баримт бичигт тусгагдсан байдал

№	Дүүргийн нэр	Дүүргийн ЗД-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан эсэх	Тусгагдсан арга хэмжээний тоо	Дүүргийн 2016-2020 оны НЭЗХҮЧ-д туссан эсэх	Тусгагдсан арга хэмжээний тоо
1	БЗД	Үгүй	-	Үгүй	-
2	БГД	Үгүй	-	Тийм	3-9
3	БНД	Тийм	7	Тийм	13-24
4	БХД	Тийм	3	Тийм	3-11
5	НД	Тийм	5	Тийм	5-20
6	СХД	Тийм	-	Тийм	10-24
7	СБД	Тийм	8	Тийм	9-23
8	ХУД	Үгүй	-	Үгүй	-
9	ЧД	Тийм	4	Үгүй	-

Дүгнэлт: Нийслэл, дүүргийн түвшинд бодлогын баримт бичгийг боловсруулахад төвийн томоохон 4 дүүрэг санал өгөөгүй нь талуудын оролцоог хангахгүй байна.

А.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэлтэй төлөвлөсөн үү?

ХЭДС-ийн орлогыг бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаагүй, үндэслэл муутай төлөвлөжээ.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг үндэслэлтэй тооцсон уу?

ХЭДТХ-ийн 21.1-д зааснаар ХЭДС нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан байна.

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын 6 дугаар зүйлийн 6.4⁶-т санхүүгийн эх үүсвэрийн талаар тусгажээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг ХЭҮЗ-ийн тогтоолоор жил бүр батлан төсвийг хуваарилан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллажээ.

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөр арга хэмжээнд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг ХЭДТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.9.1-д заасны дагуу санал боловсруулж НЗД болон ИТХ-д хүргүүлсэн байна. Нийслэл болон дүүргийн ХЭДС-ийн 2016-2021 оны төсөвт орон нутгийн төсвөөс орох орлогыг төлөвлөөгүй, зөвхөн улсын төсвөөс олгох санхүүжилтээр орлогыг бүрдүүлэхээр тусгажээ.

Дүгнэлт: Шаардлагатай санхүүжилтийг төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах үйл ажиллагааг үндэслэлгүй тооцжээ.

2.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлж, тусгасан уу?

Засгийн газрын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.1⁷-т зааснаар НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь тухайн жилд зарцуулах төсвийн

⁶ Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь улс, орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандивын хөрөнгөөс бүрдэнэ.

⁷ Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага тухайн жилд орон нутагтаа хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, тэдгээрт сан болон дэд сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр

төсөөллийн саналыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заажээ.

Хүснэгт №5 НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс төсвийн төсөлд тусгуулахаар өгсөн санал

Д/д	Нийслэл, дүүрэг нэр	Төсвийн санал өгсөн байдал					
		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	НХЭГ	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм
2	БГД	үгүй	үгүй	үгүй	тийм	тийм	тийм
3	БЗД	үгүй	үгүй	үгүй	үгүй	тийм	тийм
4	БНД	тийм	тийм	тийм	тийм	тийм	тийм
5	БХД	үгүй	үгүй	тийм	тийм	тийм	тийм
6	НД	үгүй	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй
7	СХД	үгүй	үгүй	үгүй	тийм	тийм	тийм
8	СБД	үгүй	үгүй	үгүй	тийм	тийм	Тийм
9	ХУД	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
10	ЧД	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй	тийм

ХЭҮЗ-өөс тухайн жилд хэрэгжих хөтөлбөрүүдийн санхүүжилтийг батлахдаа НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-ээс төсөвт тусгуулах саналыг харгалзан үзээгүй, хэрэгжилт хангалтгүй хөтөлбөрт дахин санхүүжилт төлөвлөдөг, дүүргүүдийн ХХҮХ-ээс зарим онуудад төсвийн төсөөлөлд санал өгсөн байдал хангалтгүй байна.

Дээрх журмын 1.4⁸-т нийслэл, дүүрэг нь хөдөлмөр эрхлэлтийн дэд сантай байна, 2.3⁹-т заасны дагуу нийслэл, дүүргийн ЗД тухайн орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж дэд санд төвлөрүүлэх гэж заажээ. Гэвч нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийн дэмжих дэд сан байхгүй байна.

Мөн НИТХ-ын тогтоолоор баталсан 2 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр нийт 47,137.6 тэрбум төгрөгийг баталсан боловч бүрэн зарцуулаагүй.

Дүгнэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тодорхойлоогүй, бүрэн ашиглаагүй байна.

2.3 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг цаг тухайд нь үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг хуваарилсан эсэх?

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогыг ХЭДТХ-ийн 30.1¹⁰-д заасны дагуу төрийн захиргааны төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ үр дүнг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 30.1.6-д зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалтыг хийх, зарцуулалтад хяналт тавих, үнэлж дүгнэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар заажээ.

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 4.6¹¹-д зааснаар төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын

эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад өмнөх оны 7 дугаар сарын 1-ний дотор хүргүүлнэ.

⁸ Сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд аймаг, нийслэл, дүүрэгт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан (цаашид "дэд сан" гэх)-тай байна.

⁹ Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ.

¹⁰ Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

¹¹ Сангийн тухайн жилийн төсвийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас боловсруулж, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална гэж заасан байна. Энэхүү заалтын хүрээнд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь ХЭҮЗ-өөс хуваарилсан төсөв санхүүгийн нөөцийг батлагдан ирсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд зарцуулж биелэлт үр дүнг тайлагнаж ажиллажээ.

Дүгнэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд шаардагдах ХЭҮЗ-өөс хуваарилсан санхүүжилтийг зарцуулжээ.


А.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын чиг үүрэг харилцан уялдаатай байна уу?

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих салбарын төрийн байгууллагуудын дүрэм, чиг үүрэг харилцан уялдаагүйгээс удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаагаа тайлагнах, харилцаа хамтын ажиллагаа хангалтгүй, холбогдох заавар журмыг баримтлан ажиллаагүй байна.

3.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө уялдаж байна уу?

ХЭДТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.1¹²-д зааснаар Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь дараах бүтцээс бүрдэж үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Үүнд:

Дүрслэл №1



НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрмийг ХЭДТХ-ийн 29.7¹³-д заасны дагуу ХНХ сайдын 2016 оны А/29 дүгээр тушаалаар дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрмийг, 2017 оны А/09 дүгээр тушаалаар НХЭГ-ийн дүрмийг баталжээ. Ингэхдээ нийслэл¹⁴, дүүргийн¹⁵ статусыг “**агентлаг**” байна гэж тодорхойлсон.

ХЭДТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3¹⁶ НХЭГ-ын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлдөг. Мөн нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд

¹²Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тогтолцоо нь хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтан /хөдөлмөрийн алба/, хөдөлмөрийн биржээс бүрдэнэ.

¹³аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагын дүрмийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална

¹⁴Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, иргэдэд хөдөлмөр, эрхлэлтийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх үйл ажиллагааг дүүрэг, хороодын онцлог, хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тэгш, хүртээмжтэй зохион байгуулах үүрэг бүхий хэрэгжүүлэгч **агентлаг** байна.

¹⁵Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хэрэгжүүлэгч **агентлаг** байна.

¹⁶Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын даргыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн шатны Засаг даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

НЗД-тай гэрээ байгуулж үйл ажиллагаагаа тайлагнаж, бүтэц орон тооны хязгаарыг тогтоож өгдөг байна.

Харин дүүргүүдийн ХХҮХ-ийн даргыг МУЗГ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4¹⁷-д заасны дагуу хөдөлмөр, нийгмийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлдөг байна.

Дээрх зохицуулалтын хүрээнд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг буюу ХХҮЕГ-т шууд харьяалагдан үр дүнгийн гэрээ байгуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг ХХҮЕГ-аас хуваарилан баталдаг байна.

НХЭГ-ийн дүрмийн 3.12¹⁸-д заасны дагуу дүүргүүдийн ХХҮХ-ийг удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааны тайланг нэгтгэх чиг үүрэгтэй боловч дүүргүүдийн ХХҮХ нь НХЭГ-тай үр дүнгийн гэрээ байгуулдаггүй тул үйл ажиллагааны уялдаа хангалтгүй байна. Энэ нь НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрмийг батлахдаа чиг үүргийг бүрэн тодорхой тусгаж өгөөгүйтэй холбоотой байна.

Дээрх байдлаас шалтгаалж төсөл хөтөлбөр давхцах цаашлаад нэг иргэнд давхардсан тоогоор сургалтад хамруулах, үр дүнгүй зардал гарах эрсдэл үүссэн байна. Энэ нь ХНХС-ын тушаалаар баталсан НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрмийг шинэчлэн баталж чиг үүргийг харилцан уялдаатай тусгах талаар арга хэмжээ авч ажиллах шаардлага бий болсон байна.

Дүгнэлт: НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн салбарын түвшинд удирдлага арга зүйгээр хангах, үйл ажиллагаагаа тайлагнах, хоорондын харилцаа, хамтын ажиллагаа хангалтгүй байна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ бүс нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээ авч байна уу?

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.3-д “Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ” гэж заасан байна. Дээрх зорилтыг хэрэгжүүлэхэд өрхийн аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, иргэдийг тогтвортой орлого олох боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хэрэгжүүлэх шаардлага үүсжээ.

2018-2019 онд ХЭҮЗ-өөс орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл хөтөлбөрийг батлан дүүргүүдийн ХХҮХ-т төсөв хөрөнгийг хуваарилан өгч хэрэгжүүлжээ. Үүнд:

Хүснэгт №6 ХЭДС-аас 2018-2019 онд хэрэгжсэн орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээний санхүүжилт

				/сая.төг/
Дүүргийн нэр	Он	Санхүүжилт	Зарцуулалт	Буцаан төвлөрүүлсэн
БЗД	2018	1,000.0	1,000.0	-
	2019	100.0	80.0	20.0
БНД	2018	100.0	100.0	-
БГД	2018	300.0	297.0	3.0
СХД	2018	200.0	200.0	-
СБД	2019	210.0	189.3	20.7
ЧД	2018	100.0	100.0	-
Нийт		2,010.0	1,966.3	43.8

¹⁷ Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрийн байгууллага, албан газрын бүтэц, дүрмийг баталж, дарга /эрхлэгч, захирал/-ыг томилж, чөлөөлнө;

¹⁸ Газар нь дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүдийг удирдлага арга зүйгээр хангаж, үйл ажиллагааны тайланг авч нэгтгэнэ.

Дээрх хүснэгтээс харахад орон нутгийн онцлог, хэрэгцээнд нийцүүлсэн төсөлд нийслэлийн 6 дүүрэгт 2,010.0 сая төгрөгийг хуваарилснаас хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн ХЭҮЗ-өөс БЗД-н ХХҮХ-т 2 жил дараалан нийт 1,080.0 сая төгрөгийг хуваарилсан байна. Бусад дүүргүүдэд 100.0-300.0 сая төгрөгийн төсвийг хуваарилжээ. Үүнээс 1,966.3 сая төгрөгийг төсөлд зарцуулан 43.8 сая төгрөгийг ХЭДС-д буцаан төвлөрүүлсэн байна. Хавсралт №2

Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийн эргэн төлөгдөх зээлийн санхүүжилт, төсөл сонгон шалгаруулалт зэргийг ХЭҮЗ-өөс баталсан тогтоолын дагуу хэрэгжүүлэхээр тусгасан.

Зорилтот төслийн тэргүүлэх чиглэлд дараах салбарын үйл ажиллагааг явуулах иргэн ААНБ-д санхүүгийн дэмжлэг олгохоор шалгуур үзүүлэлтийг баталсан байна. Үүнд:

- Салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл
- Өндөр технологид суурилсан гарааны бизнесийг дэмжих төсөл
- Агаарын бохирдлыг бууруулах, ногоон ажлын байрыг дэмжих төсөл
- Малын гаралтай түүхий эд, ХАА салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөл
- Жимс хүнсний ногоо боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжих төсөл
- Нийтийн аж ахуй үйлчилгээг сайжруулахыг дэмжих төсөл
- хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэшсэн ажилтан сургаж ажлын байранд зуучлах төсөл

Нийт шалгарсан 35 төслөөс 25 буюу 71.4% нь нийтийн аж ахуй үйлчилгээг сайжруулах төсөлд, 7 буюу 20% нь Малын гаралтай түүхий эд, ХАА салбар дахь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх төсөлд, 2 буюу 5,7% хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэшсэн ажилтан сургаж ажлын байранд зуучлах төсөлд, 1 буюу 2,9% Жимс хүнсний ногоо боловсруулах, үйлдвэрлэлийг дэмжих төсөлд олгогджээ. Салбарын тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, Өндөр технологид суурилсан гарааны бизнесийг дэмжих төсөл, Агаарын бохирдлыг бууруулах, ногоон ажлын байрыг дэмжих төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлээгүй байна. Шалтгаан нөхцөлийг тодруулахад эдгээр төсөлд иргэн, ААНБ-аас төсөл ирдэггүй гэх тайлбарыг өгсөн нь ХНХС-ын 2018 оны А/204 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Зорилтот төслийн шалгаруулалт зохион байгуулах удирдамж”-ийн 3.1¹⁹-д заасныг зөрчиж олон нийтэд ил тод нээлттэйгээр зарлан мэдээлээгүй мөн хэрэгжилтийн явц үр дүнд хяналт шинжилгээ, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт үнэлгээ хийгээгүй байна.

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн дүүргүүдийн ХХҮХ нь шаардлага хангаагүй иргэн, ААНБ-д зээлийг олгосон нь зээлийн эргэн төлөлт болон хугацаа хэтэрсэн чанаргүй зээлээс харагдаж байна.

Хүснэгт №7 Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт

/сая төг/

Дүүрэг	Хамрагдах он	Зээл олгосон иргэн, ААНБ тоо	Эргэн төлөгдөх дүн	Эргэн төлөлт хийсэн хугацаа төсөв					Төлөг-дсөн дүн	Үлдэгдэл авлага	Үлдэгдэл /Хувь/
				2018	2019	2020	2021	2022			
БЗД	2018	12	1,000.0	-	218.2	118.3	205.1	11.5	553.1	446.9	44.7
	2019	4	80.0	-	-	23.5	9.8	2.2	35.5	44.5	55.6
БГД	2018	3	297.0	-	49.2	45.5	-	-	94.7	202.3	68.1
БНД	2018	2	100.0	-	-	4.0	16.0	10.0	30.0	70.0	70.0
СХД	2018	4	200.0	-	6.9	4.0	12.0	12.0	34.9	165.1	82.6
СБД	2019	9	180.0	-	-	21.1	18.4	9.5	49.0	131.0	72.8

¹⁹ орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төслийг олон нийтэд зарлан мэдээлэх, бүртгэх, шалгаруулах, мэргэжлийн явц үр дүн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, эргэн төлөлтөд хяналт тавих гэсэн үе шаттайгаар зохион байгуулна

ЧД	2018	1	100.0	24.5	-	7.0	-	68.5	100.0	-	-
Нийт		35	1,957.0	24.5	274.3	223.4	261.3	113.7	897.5	1,059.2	45.9

Дүүргүүдийн ХХҮХ-үүд 2018-2019 онд 1,957.0 сая төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй 36 сарын хугацаатай, хүүгүй санхүүгийн дэмжлэгийг нийт 32 иргэн, ААНБ-д олгосноос 2022 оны байдлаар зээлийн хугацаа дууссан 897.5 сая төгрөгийг эргэн төлж, 1,059.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй хугацаа хэтэрсэн чанаргүй зээл болсон байна. Дүүргүүдийн ХХҮХ-т хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийг буцаан төлүүлэх талаар оновчтой арга хэмжээг аваагүй, хууль хяналтын байгууллагад хандаагүй байна.

ХЭҮЗ-ийн тогтоолд дүүргүүдийн ХХҮХ нь зээлийн хэрэгжилтийн явц үр дүнгийн хяналт шинжилгээг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийх, зээлд хамрагдсан иргэн ААНБ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах нийтэд мэдээлэх талаар тусгасан боловч дээрх үүргийг хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тооцоогүй байна.

Дүгнэлт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээг авч ажиллаагүйгээс шалгарсан төслийн хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байна.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлийг ХЭДТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.1²⁰-т зааснаар байгуулж ажиллуулна гэж заажээ.

ХЭСЗ-ийн дүрмийг ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагатай зөвшилцөн ХЭҮЗ-ийн 2017 оны 01 дугаар сарын 27-ны өдрийн №2 дугаар тогтоолоор батлан НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-ээс салбар зөвлөлийг байгуулан ажилласан байна.

ХЭДТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.7²¹-д болон “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.1²²-т т заасны дагуу нийслэл болон дүүргүүдийн салбар зөвлөлийн гишүүдийг баталж ажиллахаар заажээ. Гэвч 2017-2021 оны хугацаанд ХЭСЗ-ийн бүрэлдэхүүнд дүрэмд зааснаас өөр албан хаагчийг НХЭГ болон БНД, БГД-үүд ажиллуулж 2.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Хүснэгт №8 ХЭСЗ-ийн дүрмийн бус гишүүд

БГД	2021 оны гишүүдийн бүрэлдэхүүнд ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн ХНХ асуудал хариуцсан мэргэжилтэн
БНД	2017-2020 онд гишүүдийн бүрэлдэхүүнд Нарийн бичгийн даргаар ХХҮХ-ийн дарга
НХЭГ	2017-2021 онд гишүүдийн бүрэлдэхүүнд Нарийн бичгийн даргаар НЗДТГ-ын НБХ-ын мэргэжилтэн

Салбар зөвлөлийн дүрмийн 3.7-т зөвлөлийн гишүүдэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэмжээгээр хуралдааны оролцоог харгалзан зөвлөлийн нарийн бичгийн даргыг хамруулан урамшуулал олгохоор заасан байна.

Хүснэгт №9 ХЭСЗ-ийн үйл ажиллагааны зардал 2016-2021

/сая.төг/

№	Дүүрэг	Хуралдсан тоо	Үйл ажиллагааны зардал
---	--------	---------------	------------------------

²⁰ Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгууллагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийг байгуулж, ажиллуулна.

²¹ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

²² Зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор тухайн аймаг, нийслэл, дүүргийн засаг дарга байх бөгөөд 3 талын төлөөлөгчийн тоо адил байна.

1	НХЭГ	8	16.3
2	БГД	5	11.2
3	БЗД	9	14.9
4	БНД	10	10.3
5	БХД	35	18.0
6	НД	3	20.9
7	СХД	7	21.2
8	СБД	11	18.9
9	ХУД	10	16.4
10	ЧД	10	17.5
Нийт		108	165.6

2016-2021 онуудад нийслэл, дүүргийн ХЭСЗ нь нийт 108 удаагийн хурлыг хийж салбар зөвлөлд 165.6 сая төгрөгийн үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Гэвч ХЭСЗ-ийн дүрэм болон ХНХС-ын тушаалд зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллыг хуралдааны оролцоог харгалзан олгохоор заасан ч “оролцоо” гэдгийг ямар шалгуураар авч үзэх, ямар албан тушаалтны шийдвэрээр, хэрхэн тооцож олгох талаар тодорхой зааж өгөөгүйгээс зөвхөн хуралдааны ирцийг үндэслэн НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн даргын тушаал, ХЭСЗ-ийн даргын шийдвэрээр урамшууллыг олгосон нь бодитой бус, үр дүнг тооцоогүй.

ХЭҮЗ-өөс баталсан дүрмийн 3.5-д зөвлөл нь хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдан, зөвлөлийн хуралдаанаас эрх, үүргийнхээ хүрээнд санал, дүгнэлт, зөвлөмж, тогтоол гаргах бөгөөд хуралдааны тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулахаар заасан боловч 2017-2021 онуудад НХЭГ, БЗД, БГД, НД, СХД-ийн ХЭСЗ-үүд нь 10-с доош удаа хуралдсан, хурлын ирцийг тухай бүрд бүртгэн, баталгаажуулж ажиллаагүй байна.

НД-ийн ХЭСЗ нь 2018 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааныг гишүүдийн ирц бүрдээгүй байхад ХЭСЗ-ийг хуралдуулан 1.080 мянган төгрөгийн урамшуулал олгожээ. Энэ нь дүрмийн 3.4-т заасан “зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд хуралдааныг гурван тал тус бүрээс 2 гишүүн, нийт 6-аас доошгүй гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно” гэсэн заалтыг зөрчжээ.

ХЭСЗ-ийн дүрмийн 2.2-т салбар зөвлөлийн гишүүдийн үүргийг зааж өгчээ. Дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд тулган баталгаажуулалт хийхэд НХЭГ, дүүргүүдийн ХЭСЗ нь батлагдсан дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй. Хавсралт №3

Дүгнэлт: Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл нь хууль, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.4. Бодлогын хэрэгжилтийг бодитой тайлагнаж, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийсэн үү?

ТХЭТББ-ын хүрээнд ХЭҮЗ-өөс батлагдан хэрэгжсэн 8 хөтөлбөрийн хэрэгжилтэд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө гарган төсөл хөтөлбөрийн хэрэгжилтүүдэд дотоод мониторинг хийжээ. НЗДТГ-аас жил бүр НХЭГ-т хэрэгжсэн бодлогын баримт бичигт мониторинг хяналт шалгалтыг хийж ажилласан байна.

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь дотоод хяналт, шалгалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн боловч хэрэгжилтэд шинжилгээ, үнэлгээг бүрэн хийгээгүй, дүгнэх, арга зүйгээр хангах байдал хангалтгүй, ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоол болон 2020 оны 206 дугаар тогтоолыг баримтлан ажиллаагүй байна.

Мөн 2016-2021 онуудад хөндлөнгийн хяналт шалгалт бодлогын баримт бичигт чиглэгдэн хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.

Дүгнэлт: НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс ХЭҮЗ-өөс батлагдсан хөтөлбөр, арга хэмжээнд дотоод хяналт, шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох заавар журмыг баримтлан ажиллаагүй байна.

Б. ТӨРӨӨС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ, АЖИЛГҮЙДЛИЙГ БУУРУУЛАХ, АЖЛЫН БАЙРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР АШИГТАЙ БАЙНА УУ?

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ, нийтлэг үйлчилгээний үйл ажиллагааны үр дүн хангалтгүй, хуваарилагдан ирсэн санхүүжилтийг үр ашиггүй зарцуулсан байна.

Б.1. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?

ХЭДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.4²³-д Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг тодорхойлжээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн зөвлөгөө мэдээллээр хангах, ажилд зуучлах үйлчилгээ, ХЭҮЗ-ийн баталсан хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөсөн зорилт, хүрсэн түвшинг харьцуулахад нийтлэг үйлчилгээний арга хэмжээ, зорилтод түвшиндээ хүрээгүй байна.

АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ үр дүнг бодитоор тооцоолоогүй, сургалтын байгууллагад хуваарь хийж гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг тооцоогүй байна.

Ажлын байрны захиалга өгсөн ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлсэн болон түүнд хамрагдсан иргэн, ААНБ, ажилд олоход хүндрэлтэй иргэний талаарх бүртгэл мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн санд бүртгэх үйл ажиллагаа хангалтгүй байна.

1.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлсэн үү?

АМЧБО, зөвлөгөө өгөх

АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ХЭДТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1²⁴-д заасны дагуу НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь батлагдсан төсөл хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан байна.

АМЧБО зөвлөгөө өгөх үйлчилгээг бүлгийн болон ганцаарчилсан хэлбэрээр дараах зорилтод бүлгийн иргэдийг хамруулж зохион байгуулдаг байна. Үүнд:

Дүрслэл №2



НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь 2016-2021 онд мэргэжлийн боловсрол сургалтын эрх бүхий²⁵ 119 сургалтын байгууллагатай 526 гэрээ байгуулж, 197929 иргэн хамрагдаж, АМЧБО зөвлөгөө авах, ажлын байрны талаар мэдээллийг гэрээ байгуулан ажилласан байна.

²³ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах, нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах;

²⁴ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд тодорхой ажил, мэргэжил, ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил, мэргэжлээ сонгох болон хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдах нөхцөлийн талаар зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээ хамаарна.

²⁵ Холбогдох журмын дагуу бүртгүүлсэн, сургалт зохион байгуулах гэрчилгээтэй, мэргэжлийн сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага

Хүснэгт №10 АМЧБО зөвлөгөө авах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016-2021 он


Д/д	Дүүрэг	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
		Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/	Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/	Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/
1	НХЭГ	57654	430.2	59176	392.1	(1522)	38.1
2	БГД	6450	64.8	5487	46.4	963	18.4
3	БЗД	15378	181.3	17409	175.3	(2031)	5.9
4	БНД	3700	43.5	5900	41.5	(2200)	2.0
5	БХД	505	6.0	485	1.5	20	4.5
6	НД	6886	53.6	5441	44.0	1445	9.7
7	СБД	27687	237.7	20642	200.3	7045	37.4
8	СХД	17594	136.2	18270	131.9	(676)	4.2
9	ХУД	14391	140.6	13616	121.9	775	18.6
10	ЧД	16489	144.9	18257	144.9	(1768)	0.0
Нийт		166734	1,438.8	164683	1,299.8	2051	138.8

Нийслэл болон дүүргийн хэмжээнд ХЭДС-аас АМЧБО, зөвлөгөө өгөх үйлчилгээнд 1,438.8 сая төгрөг батлагдаж, 1,299.8 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөрт зарцуулаагүй үлдсэн 138.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаарчилсан²⁶ болон бүлгээр²⁷ зохион байгуулж, батлагдсан зардлын жишгийн дагуу санхүүжүүлдэг байна. НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-д төсвийг хуваарилахдаа нэг хүнд ногдох зардлаар нь төсөв баталдаг байна.

ХХҮЕГ-ын баталсан жишиг хэмжээнд ганцаарчилсан, бүлгээр зохион байгуулах нэг хүнд ногдох зардлыг баталж өгсөн ч зардлын задаргааг тодорхой гаргаж өгөөгүй байна. Мөн цар тахлын үе буюу 2020, 2021 онуудад ганцаарчилсан болон бүлгийн сургалтыг цахимаар зохион байгуулсан хэдий ч хуваарилагдаж буй төсөв өмнөх онуудтай харьцуулахад адилхан жишгээр батлагдсан байна.

График №1 АМЧБО төсвийн хуваарилалт



2016-2017 болон 2020-2021 онд АМЧБО үйлчилгээнд хуваарилагдсан төсвийг харьцуулахад 29% бууруулан төлөвлөжээ. Энэ нь цар тахлын үед бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн цахимаар сургалт зохион байгуулахад, үр дүнг хэрхэн тооцсон нь тодорхойгүй байна.

АМЧБО зөвлөгөө өгөх үйлчилгээнд зорилтод бүлгийн буюу ажил олоход хүндрэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа иргэн, хугацаат цэргийн алба хаагч, хорих

ангид хүмүүжсэн иргэдийг хамруулах үндсэн чиглэл зорилтыг хангаагүй, тус онуудад зохион байгуулсан сургалтууд ЕБС-ыг хамруулж цахимаар буюу zoom программаар зохион байгуулсан байна.

Үүнээс шалтгаалан зохион байгуулсан сургалтын хэрэгцээ шаардлагад нийцээгүй, зорилтод иргэдийн хүртээмж, сургалтын чанар үр дүнгүй, батлагдсан төсөв үр ашиггүй байна.

Тус арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хөдөлмөрийн асуудал эрхэлсэн АМЧБО мэргэшсэн зөвлөхийн зэрэгтэй алба хаагч мөн эрх бүхий сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр зохион байгуулна гэж заасан байна.

²⁶ 12000 мянган төгрөг

²⁷ 6000 мянган төгрөг

Үүний хүрээнд ХХҮЕГ-аас сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий байгууллагын саналыг харгалзан үзэж, шалгуур тогтоосны үндсэн дээр батлагдан ирсэн төсвийн дагуу хуваарь хийж, гэрээ байгуулан ажилласан байна.

Мэргэжлийн эрх бүхий сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулахдаа зорилтод бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн гэрээ байгуулж байгаа хэдий ч тухайн сургалтын байгууллагуудын зохион байгуулж байгаа сургалтын үйл ажиллагаанд хяналт хийж, арга зүйгээр хангах, тайлан мэдээг хянан баталгаажуулж аваагүй, түүнд үндэслэн санхүүжилтийг олгоогүй байна. Үүнээс шалтгаалан тухайн сургалтын байгууллагууд гэрээнд заасан чиг үүргийн дагуу зорилтод бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулахаас илүүтэй ЕБС-ийн сурагчдад сургалт зохион байгуулж тайлагнасан байна.

Тус арга хэмжээний хүрээнд дараах зөрчлүүд илэрсэн.

- НХЭГ 2016 болон 2020 онд ганцаарчилсан болон бүлгийн сургалт зохион байгуулаагүй. Гэвч 2017 онд “Монголын экспорт, импортыг дэмжих үндэсний төв” НҮТББ ганцаарчилсан сургалтын гэрээ байгуулсан ч тайланд бүлгийн сургалт зохион байгуулж тайлагнасан.
- 2021 онд бүлгийн сургалтаар гэрээ байгуулсан “Эл Эй Энд Си ХХК” нь 150 иргэнд сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан ч 95 иргэнд сургалт зохион байгуулсан тайлан ирүүлсэн.
- БНД-ийн ХХҮХ-тэй 2016 онд гэрээ байгуулсан “Монголын ажил мэргэжлийн мэргэшсэн зөвлөхүүдийн холбоо” 712,500 төгрөгөөр гэрээ байгуулсан ч Хэлтсийн даргын 2016.04.14 А/23 дугаар тушаалаар 896,650 төгрөг гаргаж 184,150 төгрөг цайны зардалд гаргасан.

Ажилд зуучлах арга хэмжээ

Нийслэл болон дүүргүүдийн хэмжээнд ХЭДС-аас батлагдсан төсөвт ажил зуучлах үйлчилгээнд нийт 96073 иргэнийг хамруулахад 961.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 72608 иргэнийг хамруулан 671.0 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт №11 Зуучлах үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо 2016-2021 он

/сая.төг/

Д/д	Дүүрэг	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
		Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/	Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/	Хүний тоо	Хөрөнгө /сая.төг/
1	НХЭГ	45388	464.7	29126	307.3	16262	157.4
2	БГД	8090	72.1	7101	42.1	989	30.0
3	БЗД	9660	91.3	8081	84.1	1579	7.2
4	БНД	1827	26.2	1637	11.4	190	14.8
5	БХД	550	16.7	527	5.4	23	11.3
6	НД	2028	31.6	15	19.6	2013	12.0
7	СБД	5870	56.4	1514	41.5	4356	14.9
8	СХД	10459	86.3	13435	74.8	(2976)	11.5
9	ХУД	5605	62.4	3895	35.0	1710	27.4
10	ЧД	6596	53.3	7277	49.8	(681)	3.5
Нийт		96073	961.0	72608	671.0	23465	290.0

Ажилд зуучлах үйлчилгээ нь ажлын байрыг судлах, ажил олгогчийн эрэлт хэрэгжээг тодорхойлж, ажил хайгчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажлын байранд тохирох эсэх, хувь хүний болон ур чадварын хэрэгцээ шаардлагад нийцсэн туслалцаа үзүүлэх үйлчилгээ. Тус арга хэмжээний хүрээнд иргэдийг хамруулсан томоохон өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж, иргэн ААНБ зөвлөгөө мэдээлэл өгч зуучлан ажиллах хүрээнд санхүүжилтийг гарган ажиллажээ. Гэвч зарим дүүргүүд дээрх арга хэмжээнд батлагдсан төсвийг зориулалтын бус дэмжих үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна. Тухайлбал:

- БЗД-ийн ХХҮХ нь 2016-2021 онуудад зуучлах үйлчилгээнд батлагдсан 91.3 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 84.1 сая төгрөгийг зарцуулснаас 73.2 сая төгрөгийг зориулалтын бус буюу бичгийн цаас, принтерийн хор, автомашины шатахуун /2016 онд хэлтсийн даргын автомашины шатахуунд 14.7 сая төгрөг/ зарцуулсан нь ХЭДТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.4 -заасныг зөрчсөн байна.

/Тус зөрчлийг давтан гаргахгүй байх, хариуцлага тооцуулах албан шаардлагыг Үндэсний Аудитын газраар дамжуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв./

Дүгнэлт: Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

1.2 Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн ашиглалт, бүртгэлжилт, тоо мэдээ үнэн зөв, бодитой, үр дүнтэй байна уу?

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь ХЭДТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу ажлын байрны захиалга өгсөн ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлсэн болон түүнд хамрагдсан иргэн, ААНБ, ажилд олоход хүндрэлтэй иргэний талаарх бүртгэл мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн нэгдсэн санд бүртгэж оруулна гэж заажээ.

Дээрх заалтын хүрээнд ХНХЯ-аас “Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн систем” буюу “LMIS” программыг “Ай Ти Зон” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн байна. Тус программ 2013 онд ашиглалтад орж, дүүргийн ХХҮХ-үүд 2014 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд НХЭГ 2017 оноос эхлэн үр дүн, бүртгэл мэдээллээ оруулж эхэлсэн.

Нийт 7 үзүүлэлтээр бүртгэл мэдээлэл оруулахаар программчилсан хэдий ч одоогийн байдлаар 2 өгөгдөлд бүртгэл мэдээлэл оруулж, мэдээллийн сан үүсгэн ашиглаж байна. Тухайн программд мэдээлэл оруулахад ачаалал, гацалт ихтэй, сарын дундаас хойш ачаалал эрс нэмэгддэг, 2 минут программ дээр үйлдэл хийгээгүй тохиолдолд дахин шинээр нэвтэрдэг, нэг иргэний мэдээлэл оруулахад дундаж хугацаа 5-15 минут зарцуулдаг, системийн ашиглалт хангалтгүй байна.

Хүснэгт №12 Мэдээллийн систем ашиглалт

№	Программ ашиглалтад ороход өгсөн өгөгдөл	Одоо ашиглагдаж байгаа
1	АМЧБО үйлчилгээ	АМЧБО үйлчилгээ
2	Хөдөлмөр зуучлал	Хөдөлмөр зуучлал
3	Мэргэжлийн боловсрол сургалт	-
4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	-
5	Жижиг дунд үйлдвэрлэл	-
6	Эрүүл мэнд судлал	-
7	Удирдлага тохиргоо	-

Аудитын явцад иргэд, аж ахуйн нэгжийг бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн эсэхийг тулган шалгахад дараах 2 өгөгдлөөр нийт 488483 иргэн, 216845 ААНБ-ыг бүртгэл мэдээллийг оруулсан байна.

Хүснэгт №13 Нийслэл, дүүргийн ХХҮХ-ээс LMIS-д оруулсан мэдээлэл

/хүн.тоо/

Хамрах он	АМЧБО үйлчилгээнд хамрагдсан иргэд		Хөдөлмөрт зуучлах				
	Бүлэг	Ганцаарчилсан	Зуучлал	Ажлын байр санал болгосон	Ажил олгогчийн тоо	Ажил хайгч	Ажлын байр
2016	12182	10132	15440	1291	5226	29139	37866
2017	48138	15131	21805	181	3928	26489	35461
2018	23283	19379	19497	23	2804	28135	36004
2019	30955	26045	20807	2	1118	27184	35750
2020	6648	18477	12047	2	1008	17677	29987
2021	14383	20120	11138	1	1027	14252	26666

Нийт	135589	109284	100734	1500	15111	142876	201734
------	--------	--------	--------	------	-------	--------	--------

Хүснэгт №14 Харьцуулсан судалгаа 2016-2021 он

/хүн.тоо/

Д/д	Нэрс	Мэдээллийн эх үүсвэр	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД	НХЭГ	НИЙТ
1	Ажлын байрны захиалгын тоо	LMIS программ	2351	230	13020	19033	5168	36952	7587	12813	11767	34025	142946
		ХЗЗ төлөв байдлын судалгаа	2228	636	13491	14967	5875	17320	8872	11513	11465	57195	143562
2	Бүртгүүлсэн иргэдийн тоо	LMIS программ	2380	494	12964	18906	2619	21694	9684	11641	10403	36612	127397
		ХЗЗ төлөв байдлын судалгаа	2722	1668	9460	24134	2589	21746	9913	19090	9692	41024	142038
3	Зуучилсан иргэдийн тоо	LMIS программ	1962	528	7342	9162	2600	13438	6399	6892	7431	35716	91470
		ХЗЗ төлөв байдлын судалгаа	2991	564	11522	8847	3567	15393	6769	8374	7450	45406	110883
4	АМЧБО иргэдийн тоо	LMIS программ	4259	1159	15256	13187	4349	23118	12870	12055	15104	64392	165749
		ХЗЗ төлөв байдлын судалгаа	5673	1454	16160	17527	5016	25482	12750	14313	16719	69766	184860

Дээрх хүснэгтээс харахад “LMIS” программын тоо болон ХЗЗ-ийн төлөв байдлын мэдээ хоорондоо зөрүүтэй байгаа нь ХЭДТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.9.7²⁸, 29.9.9²⁹-д заасан бүртгэл мэдээллийн санг бүрдүүлэх, шинэчлэх үүргээ хэрэгжүүлээгүй байна. Үүний улмаас нийслэл, дүүргийн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл, судалгаа бүрэн, үнэн зөв гарч чадахгүй байгааг харуулж байна.

Дүгнэлт: Нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн ашиглалт хангалтгүй, бүртгэлжилт, тоо мэдээ зөрүүтэй, үр дүн хангалтгүй байна.

1.3 Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд зарцуулсан хөрөнгийн үр ашгийг бодитой тооцож, тайлагнасан уу?

ХЭДТХ-ийн 6 дугаар зүйлд зааснаар хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ нь

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
- Ажилд зуучлах
- Ажилгүйдлийн тэтгэмж олгох
- Нэгдсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээнд хамруулах
- Бусад үйлчилгээ зэрэг арга хэмжээнээс бүрддэг байна.

2016-2021 онд нийтлэг үйлчилгээнд 1,935.0 сая төгрөг батлагдаж ирснээс 1,663.6 сая төгрөгийн зарцуулалтыг тайлагнасан байна.

Тайлангийн дэд зорилт 1.1, 1.2-т дурдсанаар ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлахад зарцуулсан хөрөнгийг тайлагнасан ч үр ашгийг бодитоор дүгнэж хяналт, шинжилгээ хийгээгүй байна.

Дүгнэлт: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамрах үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, зарцуулсан хөрөнгө үр ашиг муутай байна.

²⁸ аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ажил олоход хүндрэлтэй иргэдийн бүртгэл, хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

²⁹ хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;

Б.2. Засгийн газраас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байна уу?

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 320 дугаар тогтоолоор ТХЭТББ-ыг баталж, бодлогын хэрэгжилтийг хангахдаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр дараах төсөл хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн. Үүнд:

№	2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2017-2020 онуудад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд	2021 онд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд
1	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээг дэмжих хөтөлбөр	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйлчилгээ
2	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ	Ажилд зуучлах үйлчилгээ
3	Аж ахуй эрхлэх бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
4	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байрыг дэмжих хөтөлбөр		
5	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
7	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
8	Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
9	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төсөл	-

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т 2016-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн салбарын зардалд батлагдсан 349.9 тэрбум төгрөгөөс 51.7 тэрбум төгрөг буюу 14.7% хуваарилагдаж ирснээс 44.5 тэрбум төгрөгийг зарцуулж, 7.2 тэрбум төгрөгийг буцаан төвлөрүүлэн ажиллажээ.

Аудитаар дээрх хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр нөлөөг тулган баталгаажуулахад дараах төсөл хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал:

1. *Эрх зүйн орчин бүрэн бүрдээгүй байна.*
 - ХЭҮЗ-өөс батлан хэрэгжүүлж байгаа бодлого, тогтоол шийдвэр, дүрэм журамд жил бүр өөрчлөлт хийгдэж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэ нь санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний эргэн төлөлтийн эргэж буцсан шийдвэрүүдээс үүдэж чанаргүй буюу хугацаа хэтэрсэн зээл дүүргүүдийн ХХҮХ-дэд бий болсон байна.
 - Хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулахдаа төсөл арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг олгохоор баталдаг боловч шалгуур үзүүлэлтийг бүрэн тусгаж тодорхойлоогүй, сонгон шалгаруулалтын журам байхгүй, заавар аргачлалыг батлаагүй байна.
2. *Санхүүжилтийн төлөвлөлт тооцоо судалгаагүй байна.*
 - Хэрэгжүүлэгч байгууллагуудаас жил бүр хуулийн хугацаанд төсвийн төсөөллийн санал авдаг боловч саналыг тусган хэрэгжүүлдэггүй.
 - Хөтөлбөр төслийн зорилгыг зорилтот бүлгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн төлөвлөдөггүй.
 - Эрэлт хэрэгцээ ихтэй хөтөлбөр, арга хэмжээнд төсөв хуваарилахдаа багаар хуваарилж хэрэгцээ шаардлага багатай хөтөлбөр арга хэмжээнд төсвийг тооцоо судалгаагүй хуваарилснаас үүдэн санхүүжилтийг эргүүлэн татуулах нөхцөл байдал үүсэж байна. Төсвийн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгоогүй.

3. *Батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагын бүтэц, чиг үүрэг хангалтгүй байна.*
 - Дүүргүүдийн ХХҮХ-дэд хөдөлмөр эрхлэлтийн албаны бүтэц орон тоогоор хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн 1-2, энэ нь тухайн дүүргийн хүн ам, газар нутгийн онцлогоос шалтгаалан тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад хүрч ажиллаж чадахгүй хүндрэл бэрхшээл бий болсон байна.
4. *Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт сул байна.*
 - Хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд холбогдох харьяа байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эх үүсвэр, төсөв, тусгай зориулалтын сан, төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй.
 - Дотоод мониторинг, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.
5. *Нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан тоо мэдээг үнэн зөв бодитоор тайлагнаагүй байна.*
 - Хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан иргэдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдээгүй, мэдээллийн системийн ашиглалт хангалтгүй.

2.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, олон улсын байгууллагуудын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна уу?

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах чиглэлээр гадаад болон дотоодын зээл, ОУБ-ын санхүүжилттэй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг ТХЭТББ-д заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.7³⁰-д зааж өгчээ.

ХЭДС-ийн орлогын эх үүсвэрийг ХЭДТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.5³¹, 22.1.6³²-д гадаадын зээл, ОУБ-аас өгсөн хандив, зээл тусламжийг тусган өгчээ.

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь 2016-2019 онуудад тус хөтөлбөрийн хүрээнд гадаад болон дотоодын зээл, тусламж, бүх төрлийн сан, ОУБ-ын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна. 2020-2021 онуудад дараах төсөл хөтөлбөр хэрэгжжээ. Хавсралт №4

Хүснэгт №15 ОУБ-аас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр

Д/д	Дүүргийн нэр	ОУБ-ын санхүүжилтээр	Хэрэгжүүлсэн байгууллага	Олгосон санхүүжилт	/сая.төг/	
					Хэрэгжилт	Биелэлт хувь
1	НХЭГ	Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар	22.0	22.0	100
2	БГД	Дэлхийн банк	БГД ХХҮХ	243.6	131.5	54
2	БЗД	Швейцарын хөгжлийн агентлаг	БЗД ХХҮХ	8.0	8.0	100
3	БНД	Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг	БНД ХХҮХ	131.6	69.2	52.6

³⁰ гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулах

³¹ гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл

³² гадаад улс, олон улсын байгууллагаас, Монгол улсын болон гадаад аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж

4	БХД	Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг	ХНХЯ, ХХҮЕГ	98.6	60.6	61.5
5	НД	Дэлхийн банкны төслийн санхүүжилт	ХНХЯ, ХХҮЕГ	19.1	3.6	18.8
6	СБД	Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг	“Алтан алхам” төрийн бус байгууллагын дэргэдэх сургалтын төв, GFA Консалтинг групп	33.1	33.1	100
7	СХД	Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг	СХД Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв, Койт трейд ХХК, Алтан Алхам ТББ	184.5	184.5	100
8	ХУД	Дэлхийн банкны санхүүжилттэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр	ХУД ХХҮХ	150.6	150.6	100
9	ЧД	Дэлхийн банк	ХНХЯ, ХХҮЕГ	74.2	26.3	35.4
Нийт				965.3	689.4	71.4

ОУБ-ын санхүүжилтээр 2020-2021 онуудад 965.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 689.4 сая төгрөг буюу 71.4%-ийн хэрэгжилттэй байна. НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр залуучуудын хөгжлийн төв байгуулан доторх тохижилт, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил болон сургалтын үйл ажиллагааг санхүүжүүлсэн нь хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг дэмжих салбарын үйл ажиллагааг хүртээмжтэй, үр дүнтэй явуулахад дэмжлэг болжээ.

Дүгнэлт: Гадаад болон дотоодын зээл, тусламж, ОУБ-ын санхүүжилтээр 2020-2021 онд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр үр дүнтэй байна.

2.2 Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, санхүүжилт, үр дүнг бодитой тайлагнаж, үнэлсэн үү?

Аудитад хамрагдсан он буюу 2016-2021 онуудад санхүүжилт 3-5 дугаар саруудад батлагджээ. Энэ нь ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 4.7³³-д заасан хугацаа хоцорч санхүүжилтийг олгосон байна.

Үүнээс харахад эхний хагас жилд санхүүжилтгүйгээс төсөл хөтөлбөр хугацаа алдаж хэрэгжих энэ хугацаанд зорилтот иргэд үйл ажиллагаанд хамрагдаж чадахгүй байна. Төсөл хөтөлбөр түүнийг хэрэгжүүлэх санхүүжилт батлагдсан хугацаанд ирээгүйгээс шалтгаалж иргэдийн идэвх оролцоо сул, ирж буй төсөл хөтөлбөр хангалтгүй, хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй болж байна. Иргэдийн хувьд жилийн эхний хагаст идэвхтэй байдаг бөгөөд зуны амралт, намрын ажил, хичээл сургуулийн үед ХЭДХ төслүүдэд хамрагдах идэвх сул харагдаж байна.


Иймээс жил эхэлмэгц ХЭДС-ийн санхүүжилт, холбогдох хууль тогтоомж журам зааврыг цаг хугацаанд нь олгож, хөтөлбөр төслүүдийг оны эхнээс хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна.

³³ Сангийн батлагдсан төсвийг аймаг, нийслэл, дүүрэгт хуваарилахдаа хүн амын тоо, ажилгүйдэл, ядуурлын түвшин, хамрагдах хүний тоо зэргийг үндэслэн аймаг, нийслэл дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын саналыг харгалзан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. Энэхүү хуваарийг санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 1 дүгээр сард багтаан хүргүүлж байна.



График №2 ХЭҮЗ-өөс батлагдаж НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т батлагдан ирсэн хугацаа

ХЭДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3³⁴-т зааснаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг дараах байдлаар хэрэгжүүлнэ.



1. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр /АБДХ/

Хувиараа болон нөхөрлөл, хоршоо бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болоод бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж ажлын байрыг бий болгох, ажил олгогчид урамшуулал олгох, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангах, орлого нэмэгдүүлэх зорилготойгоор хэрэгжүүлсэн байна.

2016-2021 онуудад АБДХ-ийг нийслэл болон дүүргүүдэд дараах байдлаар зохион байгуулжээ. Үүнд:

³⁴ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг дараах төсөл хөтөлбөрийн хэлбэрээр хэрэгжүүлнэ:

Дүрслэл №3 АБДХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээ



ХЭҮЗ-өөс 2015-2021 оны хооронд АБДХ-т дараах өөрчлөлтийг оруулан баталжээ.

Хүснэгт №16 Хөтөлбөрийн өөрчлөлт

Хэрэгжсэн он	2015-2016	2017-2020	2021
Тогтоолын дугаар	09-р тогтоол	01-р тогтоол	01-р тогтоол
Хөтөлбөрийн өөрчлөлт	Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг хөтөлбөр	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр

АБДХ-т 2016-2021 онуудад нийслэл болон дүүргүүдийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 22,092.7 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээрээ 18,112.4 сая төгрөг буюу 82%-ийг зарцуулж 3,980.3 сая төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт №17 АБДХ-ийн 2016-2021 оны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	НХЭГ	2,233.7	1,962.8	270.9	87.9
2	СХД	4,047.8	3,463.6	584.2	85.6
3	БГД	3,398.8	2,541.0	857.8	74.8
4	БЗД	2,936.2	2,534.7	401.5	86.3
5	ЧД	2,401.9	2,121.8	280.1	88.3
6	СБД	2,298.3	1,503.3	795.0	65.4
7	ХУД	2,095.2	1,631.8	463.4	77.9
8	НД	1,240.3	1,058.2	182.1	85.3
9	БНД	926.0	869.3	56.7	93.9
10	БХД	514.5	425.9	88.6	82.8
НИЙТ		22,092.7	18,112.4	3,980.3	82.0

НХЭГ-т 2016-2021 онд 2,233.7 сая төгрөгийн төсөв хуваарилагдан ирснээс 1,962.8 сая төгрөгийг тус хөтөлбөрт зарцуулж, 270.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж хөтөлбөрийг 87.9%-тай хэрэгжүүлсэн байна.

2020 онд ХЭДС-аас 364.8 сая төгрөгийн төсөв хуваарилагдан ирснээс 344.7 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс нийтийг хамарсан арга хэмжээнд 20.0 сая төгрөгийн төсөв батлагдсан ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хэрэгжүүлээгүй байна. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлээгүй ч 11.9 сая төгрөгийг зам талбайн тохижилт, цэвэрлэгээ болон ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах ажилд ашиглах шуудай, маск, бээлий зэргийг авахад зарцуулжээ.

Дүүргүүдийн ХХҮХ-т 2016-2021 онд 19,859.0 сая төгрөгийн төсөв хуваарилагдан ирснээс 16,149.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилт дүүргүүдэд 65-93% хэрэгжилттэй байгаагаас СБД-ийн ХХҮХ нь 2,298.3 сая төгрөгийн төсөв батлагдан ирснээс 1,503.3 сая төгрөгийг зарцуулж 65.4%-ийн гүйцэтгэлтэй буюу нийслэлийн дүүргүүдээс хамгийн бага хэрэгжилттэй, БНД-ийн ХХҮХ нь 935.2 сая төгрөгийн төсөв батлагдан ирснээс 869.2 сая төгрөгийг зарцуулж 93,8%-ийн хэрэгжилттэй байна.

АБДХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг аж ахуй, бичил бизнесийг эрхлэх хүсэлтэй 35-аас дээш насны хөдөлмөрийн насны иргэн болон гадаадад амьдарч байгаа иргэний төсөл хэрэгжих үндэслэлийг харгалзан шалгаруулж 5.0 сая хүртэлх төгрөгийн дэмжлэгийг нэг удаа олгодог байна.

Аудитын хамрах онуудад 6416 төсөл ирүүлснээс 3251 төслийг сонгон шалгаруулж 10,132.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Үүнээс 3,836.1 сая төгрөг буюу 37.9% эргэн төлж, 6,296.0 сая төгрөг буюу 62.1% зээлийн үлдэгдэлтэй байна. Үүнээс 1,148.1 сая төгрөг буюу 18.2% нь хугацаа хэтэрсэн зээл байна.

- БНД-ийн ХХҮХ 2017 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг зохион байгуулахдаа төсөвт хуваарилагдан ирсэн 124.7 сая төгрөгөөс гүйцэтгэлээр 156.0 сая төгрөгийг зарцуулж, 31.3 сая төгрөгийг илүү санхүүжүүлсэн.
- /Тус зөрчлийг давтан гаргахгүй байх, хариуцлага тооцуулах албан шаардлагыг Үндэсний Аудитын газраар дамжуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв./
- БЗД-ийн ХХҮХ 2018 онд АБДХ-т 768.6 сая төгрөг хуваарилагдан ирснээс 608.3 сая төгрөгийг зарцуулж 160.3 сая төгрөгийг буцаан татуулжээ. Үүнээс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 151 иргэнд 453.0 сая төгрөг төлөвлөснөөс 63 иргэнд 354.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Төсөл шалгарсан 63 иргэний 10 иргэнд олгох 30.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн зээлийг төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулж тухайн иргэний дансанд шилжүүлэлгүйгээр хэлтсийн даргын 2018 оны 08 сарын 21-ний өдрийн А/74 дугаар тушаалаар “Зөв амьдрах ухаан” ТББ-ийн дансанд шилжүүлсэн. Энэ нь ХЭДТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3³⁵-т заасныг мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2³⁶, 16 дугаар зүйлийн 16.5.5³⁷-т заасныг тус тус зөрчжээ.

Хүснэгт №18 АБДХ-ийн 2016-2021 оны эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн зээлийн эргэн төлөлт, чанаргүй зээлийн үлдэгдэл

Д/д	Дүүрэг нэр	Зээл хүссэн иргэдийн тоо	Шалгарсан төслийн тоо	Олгосон зээл	Зээлийн эргэн төлөлт	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн хэмжээ
1	БГД	615	354	1,319.5	593.7	725.7	725.7
2	БЗД	1091	455	1,938.0	506.7	1,221.2	637,4
3	БНД	248	190	444.6	146.2	298.4	28.9
4	БХД	88	63	267.0	137.5	129.4	24.0
5	НД	680	201	565.2	219.7	298.2	55.1
6	СХД	1899	1002	2,188.5	788.3	1,080.6	28.6
7	СБД	458	256	949.5	461.1	488.3	111.7
8	ХУД	449	277	1,190.3	605.7	584.5	174.1
9	ЧД	888	453	1,269,5	377.2	892,2	190,8
Нийт		6416	3251	10,132.1	3,836.1	6,296.0	1,148.1

³⁵ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

³⁶ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх

³⁷ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

ХЭҮЗ-ийн тогтоолоор 2015 болон 2017 онуудад эргэн төлөгдөх нөхцөлд дараах өөрчлөлт оруулжээ.

Дүрслэл №4 Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийн нөхцөл



ХЭҮЗ-өөс эргэн төлөлттэй холбоотой эргэж буцсан нөхцөлтэй шийдвэр гаргаж байгаагаас үүдэн иргэдэд өөрийн авсан зээлийг тэглэх, эргэн төлөлтгүй болгох эсэх төөрөгдөл үүсэж байгаа нь иргэдийн авсан санхүүгийн дэмжлэгийг цаг тухайд нь төлөхгүй байх, чанаргүй зээл бий болох, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт буурч байгаа нь цаашид хөтөлбөр үр дүнтэй хэрэгжихэд сөргөөр нөлөөлж санхүүгийн дэмжлэгт олгосон арга хэмжээ үр ашиггүй болох эрсдэлтэй байна.

Зээлийн эргэн төлөлтийг 24-36 сарын дотор иргэний саналыг үндэслэн төлбөрийн график тогтоож эргэн төвлөрүүлэхээр тус хөтөлбөрт тусгажээ. 1,148.1 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл нь 2016-2017 оны санхүүгийн дэмжлэгийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдэл бөгөөд шүүхийн байгууллагад хандсан ч одоогоор үр дүнд хүрээгүй байна.

2016-2017 оны чанаргүй зээлийн үлдэгдлийг шүүхийн байгууллага руу хандан өгсөн ба харин 2018-2021 онуудад олгосон санхүүгийн дэмжлэгийн зээлийг зээлийн эргэн төлөлтийн хугацаа буюу 36 сар дуусаагүй гэх шалтгаанаар хууль хяналтын байгууллагад өгөөгүй ямар нэгэн арга хэмжээ аваагүй зээлийн эргэн төлөлттэй холбоотой нэхэмжлэлийг тэр даруй гаргаагүй байна.

2.Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр /АМЗҮХХ/

Ахмад мэргэжилтнүүдийн хүсэлтэд үндэслэн ажил, хөтөлбөрт оролцох оролцоог нэмэгдүүлж мэдээллийн нэгдсэн сан үүсгэн, тэдний дэмжлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэн хөдөлмөрийн дадал туршлага олгох чиглэлээр ажиллуулж, орлогын дэмжлэг үзүүлдэг байна. Хөтөлбөр нь дараах байдлаар хэрэгжсэн байна.



АМЗҮ-г 2016-2021 онуудад дүүргүүдийн ХХҮХ зохион байгуулсан. Харин НХЭГ-т тус хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд

дүүргүүдэд ХЭДС-аас 1,938.4 сая төгрөгийг хуваарилснаас 1,624.5 сая төгрөгийг зарцуулжээ.

Хүснэгт №19 АМЗҮХХ-ийн 2016-2021 оны төсвийн гүйцэтгэл, хэрэгжилт

/сая.төг/

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	БГД	297.6	208.6	89.0	70.1
2	БЗД	387.3	319.7	67.6	82.5
3	БНД	106.0	100.7	5.3	95.0
4	БХД	92.1	74.8	17.3	81.2
5	НД	101.2	81.7	19.5	80.7
6	СХД	157.3	122.9	34.4	78.1
7	СБД	280.4	242.7	37.7	86.6
8	ХУД	259.3	242.8	16.5	93.6
9	ЧД	257.2	230.6	26.6	89.7
Нийт		1,938.4	1,624.5	313.9	83.8

Дээрх хүснэгтээс харахад АМЗҮХХ-т 92.1-387.3 сая төгрөгийг тухайн онуудад хуваарилжээ. Үүнээс ТББ-аар дамжуулан зөвлөх үйлчилгээг зохион байгуулах арга хэмжээнд нийт төсвийн 60 орчим хувийг хуваарилж үлдсэн хувийг санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд хуваарилсан байна.

Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт жилд дунджаар 10-15 иргэнд 3.0 сая төгрөгийг 100% эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр ХЭҮЗ-өөс батлан хэрэгжүүлсэн байна. Гэвч ахмад иргэдээс тухайн хөтөлбөртэй холбогдуулан эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд ирүүлж буй төслийн эрэлт хэрэгцээ их байна. 2016-2021 онуудад эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг арга хэмжээний хүрээнд нийт 465 иргэнд 827.5 сая төгрөгийн зээл өгсөн нь хөтөлбөрт батлагдсан арга хэмжээний 50.9 %-ийг эзэлж байна.

АМЗҮ-г бүтээн байгуулалт болон бусад салбарын ААНБ-д АМЗҮ үзүүлэх ахмадын багийг улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлдэг ахмадын эрх ашгийг хамгаалсан мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж үзүүлэхэд чиглэн хэрэгжүүлснээр хөтөлбөрийн хэрэгжилт 83.8% хэрэгжсэн байна.

3.Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /ХБИХЭДХ/

ХЭДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3.7³⁸, 15 дугаар зүйлийн 15.1.5³⁹ дах заалтыг үндэслэн ХБИ-ийг аж ахуй эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ХБИ-ийг ажлын байраар хангасан ААНБ-д санхүүжилт олгох, урамшуулах зорилгоор ХЭҮЗ-өөс 2016-2021 онуудад “ХБИХЭДХ”-ийг баталжээ. Нийслэлд 2020 оны байдлаар 35556 ХБИ байна.

Хүснэгт №20 2016-2020 оны нийслэлийн хэмжээний ХБИ-ийн тоо

/хүн.тоо/

Он	Нийслэл	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
2016	33713	987	164	4693	7794	1760	7284	3181	3861	3989
2017	34246	1004	157	4819	7638	1731	7254	3138	3899	4606
2018	35589	1039	163	5873	8026	1626	7857	2974	3930	4101
2019	34860	1063	168	5636	7558	1582	7578	3220	3872	4183

³⁸хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад төсөл, хөтөлбөр.

³⁹хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээд асрамжийн газраас гарсан болон хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангаж, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх талаар тодорхой санаачилга гаргаж, үр дүнд хүрсэн ажил олгогчийг тусгай болзлын дагуу Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл шалгаруулж, урамшуулах.

2020	35556	1076	174	5845	8206	1560	7411	3134	4047	4103
------	-------	------	-----	------	------	------	------	------	------	------

Эх сурвалж: Нийслэлийн статистикийн газар

ХБИ-ийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах замаар ХБИ-нд зориулсан ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой хэрэгжсэн байна.



ХЭҮЗ-өөс батлагдсан хөтөлбөрт 8,165.6 сая төгрөг зарцуулахаар төсөвлөгдсөнөөс 8407 иргэнд 6,604.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №21 ХБИХЭДХ-т зарцуулсан хөрөнгө нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 он /сая.төг/

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	НХЭГ	363.0	254.3	108.7	70.0
2	БГД	1,216.4	961.6	254.8	79.1
3	БЗД	1,398.7	1,241.2	157.5	88.7
4	БНД	348.8	249.3	99.5	71.5
5	БХД	234.3	151.0	83.3	64.4
6	НД	415.9	331.0	84.9	79.6
7	СХД	1,569.8	1,266.1	303.7	80.7
8	СБД	938.5	765.0	173.5	81.5
9	ХУД	860.0	691.4	168.6	80.4
10	ЧД	820.2	694.0	126.2	84.6
Нийт		8,165.6	6,604.9	1,560.7	80.9

2016-2021 онд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т ХБИ-ний хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээг зохион байгуулж, ажилд зуучлах үйлчилгээ үзүүлэн санхүүгийн дэмжлэгийн төслүүдийг хүлээн авч сонгон шалгаруулан ХЭДС-аас нэг иргэнд 5.0 сая хүртэлх төгрөгийг нийт 2168 иргэнд 4,621.6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Шалгарсан төслийн хүрээнд шинээр 2168 ажлын байр бий болжээ.

Сургалт: ХНХС-ын ХЭД үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ноогдох зардлын хэмжээг тогтоосон тушаалаар ХБИХЭДХ-т сургалтын зардлыг тогтоож НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс сургалтын байгууллагатай гэрээ байгуулан төлбөрийн гүйлгээг хийж сургалт зохион байгуулж байгаа хэдий ч хяналт хэрэгжүүлдэггүй,

сургалтаас гарах үр дүнг тооцдоггүй, бодит үнэлгээ дүгнэлт хийдэггүй, тайлан мэдээ хангалтгүй байгаа нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй сургалтын арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байна.

Санхүүгийн дэмжлэг: Нийслэлд 2020 оны жилийн эцсийн байдлаар 35556 ХБИ байна. ХЭҮЗ-өөс тухайн жилд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т хуваарилж байгаа иргэдийн тоо түүнд төсөвлөсөн зардлын хэмжээ харилцан адилгүй байна.

График: №4

Нийт ХБИ-ийг хөтөлбөрт хамрагдсан иргэнтэй харьцуулсан харьцаа



ХЭҮЗ-өөс төсвийн хуваарь хийхдээ хүн амын тоонд төлөвлөж хэрэгжүүлдэггүй мөн дүрэм журмын өөрчлөлтийг дүн шинжилгээ хийхгүйгээр жил бүр өөрчлөлт оруулж, тогтоолд тусгаж баталж байгаа нь хэрэгжилтийг хангуулж буй хэлтэс алба, иргэдэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгосноор эрсдэл учруулсан байна. Тухайлбал санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №22 ХЭҮЗ-өөс ХБИ-ний санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд хийсэн өөрчлөлт

Д/д	Хэрэгжсэн он	Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ	Эргэн төлөх хугацаа	Эргэн төлөх нөхцөл
1	2015	5 сая хүртэлх төгрөг	48 сар	100 хувь эргэн төлнө
2	2016	5 сая хүртэлх төгрөг	-	Эргэн төлөлтгүй
3	2017-2019	5 сая хүртэлх төгрөг	48 сар	100 хувь эргэн төлнө
4	2020	5 сая хүртэлх төгрөг	48 сар	50 хувь эргэн төлнө
5	2021	3-5 сая хүртэлх төгрөг	36 сар	50 хувь эргэн төлнө

ХЭҮЗ-өөс эргэн төлөлттэй холбоотой шийдвэрийг жил бүр өөрчлөн баталж байгаагаас иргэдэд эргэлзээ төрүүлэх, хэрэгжилтийг хангуулж байгаа алба хаагчдад ойлгомжгүй нөхцөл бий болох иргэдийн зүгээс зээлийн эргэн төлөлтийг буцаан төлөхгүй байх эргэн төлөлтгүй хөтөлбөрт хамрагдсан иргэдтэй барьцах зэрэг асуудлууд үүсгэж байгаа нь хугацаа хэтэрсэн чанаргүй зээл бий болоход нөлөөлжээ.

ХБИ-ийн төсөл хөтөлбөрийн хүрээнд гарсан зөрчил:

- БЗД-ийн ХХҮХ 2018 онд ХБИХЭДХ-т 270.6 сая төгрөг хуваарилагдан ирснээс 233.5 сая төгрөгийг зарцуулж 37.1 сая төгрөгийг буцаан татуулжээ. Үүнээс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 37 иргэнд 185.0 сая төгрөг төлөвлөснөөс 45 иргэнд 185.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. Төсөл шалгарсан 45 иргэний 7 иргэнд олгох 31.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн зээлийг төсөл хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулж тухайн иргэний дансанд шилжүүлэлгүйгээр

хэлтсийн даргын 2018 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А/75 дугаар тушаалаар “Зөв амьдрах ухаан” ТББ-ийн дансанд шилжүүлсэн. Энэ нь ХЭДТХ-ийн 23 дугаар зүйлийн 23.3⁴⁰-т заасныг мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2⁴¹, 16 дугаар зүйлийн 16.5.5⁴²-т заасныг тус тус зөрчжээ.

- СХД-ийн ХХҮХ 2020 онд ХБИХЭДХ-т 225.4 сая төгрөг хуваарилагдан ирснээс 181.3 сая төгрөгийг зарцуулж 44.1 сая төгрөгийг буцаан татуулжээ. Үүнээс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 35 иргэнд 175.0 сая төгрөг төлөвлөснөөс 67 иргэнд 140.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж хэрэгжилт 80% байна. Эдгээр 67 иргэнд 140.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх сонгон шалгаруулалтыг явуулах ажлын хэсэг хуралдсаныг нотлох баримт бичиг байхгүй. Хэрхэн сонгон шалгаруулсан нь тодорхой бус энэ нь нотлох баримтын шаардлага хангаагүй.

4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр /МХЭДХ/

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар цөөн малтай болон малгүй иргэдийг ажлын байртай болгох зорилгоор хэрэгжжээ.

Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээгээр зохион байгуулсан байна.

Үүнд:

- Өрхийг малжуулах
- Мал, маллагааны арга ажиллагаа, аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт, арга хэмжээг зохион байгуулах
- Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

Тус хөтөлбөрийг нийслэлийн алслагдсан дүүрэг болох БНД, БХД, НД-дэд хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №23 МХЭДХ-ийн гүйцэтгэл, хэрэгжилт 2016-2021

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /сая.төг/ /хувиар/
1	БНД	301.3	210.5	90.8	69.9
2	БХД	234.7	119.5	115.2	50.9
3	НД	377.2	350.7	26.5	93.0
НИЙТ		913.2	680.7	232.5	74.5

2016-2021 онд ХЭҮЗ-өөс батлагдсан дээрх хөтөлбөрт 913.2 сая төгрөг зарцуулахаар төсөвлөгдсөнөөс 680.7 сая төгрөгийг зарцуулан 91 өрхийг малжуулсан байна.

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дүүргүүдийн ХХҮХ нь ХЭҮЗ-өөс баталсан тогтоолын дагуу малжуулах арга хэмжээг зохион байгуулахдаа малыг зах зээлийн дундаж үнээс илүүгүйгээр худалдан авч хамрагдах малчин өрхөд дэмжлэг үзүүлэн гэрээ байгуулжээ. Санхүүгийн дэмжлэгийг мал худалдан авч өгснөөс хойш 24-36 сарын дотор хуваарийн дагуу 100% мөнгөн хэлбэрээр төлөхөөр тусгасан байна. Өрхийг малжуулах арга хэмжээний хүрээнд санхүүгийн дэмжлэгийг үзүүлэхдээ хөтөлбөр хэрэгжүүлж буй ХХҮХ-ээс санхүүжилтээр бус малын тоо толгойгоор нь малчин өрхөд хүлээлгэн өгч буй тул зээлийн эргэн төлөлт хэвийн хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнтэй байна.

Малжуулах үйл ажиллагаа төсөл хөтөлбөрт 2016-2018 онуудад хөдөлмөрийн чадвартай 15-39 насны 2-с доошгүй гишүүнтэй малчин өрхийг хамруулж байсан бол

⁴⁰ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

⁴¹ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх

⁴² батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

2019-2020 онуудад өөрчлөлт орж хөдөлмөрийн чадвартай 18-45 насны 2-с доошгүй гишүүнтэй малчин өрхийг хамруулахаар болсон байна. Энэ нь малжуулах арга хэмжээнд залуу малчид хандаж амьжиргаагаа дээшлүүлж ажлын байрыг нэмэгдүүлж байна. Цаашид тус хөтөлбөрт хэрэгжүүлэх арга хэмжээг нэмэгдүүлж мал маллах хүсэлтэй иргэдийг зуучилж тогтвортой ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

5.Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр /ЗХЭГБДХ/

Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1-т зааснаар Монгол улсын иргэн 15-34 насны ажилгүй, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах, аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар, шинэлэг санаанд тулгуурлан гарааны дэмжлэг олгох, бизнесээ тогтвортой эрхлэхэд туслах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжжээ. Хөтөлбөрийг дараах арга хэмжээгээр зохион байгуулсан байна.

Дүрслэл №7 ЗХЭГБДХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээ



Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргаж аж ахуй эрхлэх төсөл боловсруулсан шилдэг “Старт-ап” залуу, залуучуудын багийг шалгаруулж дэмжлэг олгосноор залуучуудын гарааны бизнест дэмжлэг олгох

Тус хөтөлбөрт 2016-2021 онд нийслэл болон дүүргийн хэмжээнд ХЭДС-аас 5,688.8 сая төгрөг батлагдаж, 4,127.5 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөрт зарцуулаагүй үлдсэн 1,561.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэн, хөтөлбөрийг 72.6%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №24 ЗХЭГБДХ-т зарцуулсан хөрөнгө нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 он /сая.төг/


Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	НХЭГ	799.4	640.5	158.9	80.1
2	БГД	727.3	581.5	145.8	80.0
3	БЗД	770.3	577.3	193.0	74.9
4	БНД	314.7	214.7	100.0	68.2
5	БХД	185.0	125.1	59.0	67.6
6	НД	393.6	286.3	107.3	72.7
7	СХД	796.3	540.0	256.3	67.8
8	СБД	544.1	281.1	263.0	51.7
9	ХУД	513.2	359.0	154.2	70.0
10	ЧД	644.9	522.0	122.9	80.9

Нийт	5,688.8	4,127.5	1,561.2	72.6
------	---------	---------	---------	------

Залуучуудад хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг бий болгох ажлын байрыг нэмэгдүүлэх тэднийг мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагаар сургалт олгох мэргэшүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллахад дэмжих үйл ажиллагааны хүрээнд дээрх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүний хүрээнд гарааны бизнесийг олгох үйл ажиллагаа сонгон шалгаруулалт өрсөлдүүлэх замаар төсөл хөтөлбөрийг олгож байгаа боловч залуучуудаас ирүүлж буй төсөл хөтөлбөр бага, залуучуудад хүрч буй мэдээ мэдээлэл дутмаг байдлаас шалтгаалж хэрэгжилт, үр дүн хангалтгүй байна.

Гарааны бизнест дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ дараах байдлаар өөрчлөлтийг оруулан хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Дүрслэл №8 Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ



2018-2020 оны Старт-ап арга хэмжээний эргэн төлөлт нь 24-36 сарын хугацаанд 100 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй байсныг 2021 онд эргэн төлөлтгүй болгосноор өмнө онд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан залуучууд тухайн өөрчлөлтөөс шалтгаалж зээлийн эргэн төлөлтийг төлөхөөс зайлсхийх тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлж буй алба хаагч болон иргэдийн хооронд үл итгэлцэл үүсэх, чанаргүй зээлийн үлдэгдэл бий болох нөхцөл бүрдэж үр дүнг бууруулсан байна. Өөрчлөлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №25 ЗХЭГБДХ-ийн Старт-ап арга хэмжээнд олгох санхүүгийн дэмжлэгийн өөрчлөлт

Д/д	Хэрэгжсэн он	Дэмжлэгийн хэмжээ	Эргэн төлөх хугацаа	Эргэн төлөх нөхцөл
1	2018-2019	10 сая төгрөг	24 сар	100 хувь эргэн төлөлттэй
2	2020	10 сая төгрөг	36 сар	100 хувь эргэн төлөлттэй
3	2021	10 сая төгрөг	-	Эргэн төлөлтгүй

Нийслэл болон дүүргийн хэмжээнд 2016-2021 онд 511 төсөлд 3,200.2 сая төгрөгийн зээлийг олгосноос 971 сая төгрөгийг эргэн төлж 2,091.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл байгаагаас 1,005.1 сая төгрөг хугацаа хэтэрч чанаргүй болсон байна. ХЭДС-аас нэг иргэнд 10.0 сая хүртэлх төгрөгийг нийт 515 иргэнд 1,912.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Шалгарсан төслийн хүрээнд шинээр 515 ажлын байр бий болжээ.

Хүснэгт №26 ЗХЭГБДХ-т олгосон санхүүгийн дэмжлэгийн зээлийн эргэн төлөлт, чанаргүй зээлийн үлдэгдэл нийслэл дүүргийн хэмжээнд 2016-2021 он

/сая.төг/

Д/д	Дүүрэг нэр	Зээл хүссэн иргэдийн тоо	Шалгарсан төслийн тоо	Олгосон зээл	Зээлийн эргэн төлөлт	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн хэмжээ
1	НХЭГ	45	27	180.0	157.5	22.4	22.4
2	БГД	198	50	472.0	140.3	331.6	331.6
3	БЗД	186	62	481.0	63.0	357.9	150.5
4	БНД	94	33	188.0	67.9	120.1	5.0

5	БХД	24	17	111.0	44.7	66.2	22.3
6	НД	194	48	268.0	57.3	178.6	42.0
7	СХД	159	129	432.2	158.0	242.1	87.8
8	СБД	155	28	260.0	41.9	205.0	48.6
9	ХУД	135	19	334.0	100.7	233.2	151.5
10	ЧД	226	98	474.0	139.7	334.2	143.4
НИЙТ		1,416	511	3,200.2	971	2,091.3	1,005.1

6.Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр:
ХБХЭУЧОХ

Иргэдийг хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох сургалтад хамруулж, хөдөлмөрийн зах зээлд бэлтгэн, ажлын байранд дадлагажуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой хэрэгжсэн байна. Тус хөтөлбөр нь 2021 онд хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр болон дангаар хэрэгжсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээгээр зохион байгуулсан байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ
- Мэргэжлийн болон давтан сургалт
- Үйлдвэрлэл дээрх сургалт

Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ иргэний суралцах мэргэжлийн чиглэл хэлбэр боломжийн талаар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх нийтлэг үйлчилгээнд хамруулан мэргэжлийн сургалтын байгууллагаар сургалт зохион байгуулж чадамжийн гэрчилгээ олгож ХЭУЧ-тай болсон хүнийг ажлын байраар хангаж хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх чадвар дээшилж ажилгүйдлийн түвшнийг бууруулахад чиглэсэн байна.

Хүснэгт №27 ХБХЭУЧОХ-т зарцуулсан хөрөнгө нийслэл, дүүргийн хэмжээнд 2016-2021 он /сая.төг/

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	НХЭГ	1,423.5	1,198.0	225.5	84.2
2	БГД	140.7	48.9	91.8	34.8
3	БЗД	200.2	132.3	67.9	66.1
4	БНД	79.5	46.3	33.2	58.2
5	БХД	42.6	11.9	30.7	27.9
6	НД	98.8	62.4	36.4	63.2
7	СХД	196.5	135.8	60.7	69.1
8	СБД	126.2	30.6	95.6	24.2
9	ХУД	69.2	46.3	22.9	66.9
10	ЧД	67.2	63.9	3.3	95.1
Нийт		2,444.4	1,776.4	668.0	72.7

Нийслэл болон дүүргийн хэмжээнд ХЭДС-аас 2,444.4 сая төгрөг батлагдаж, 1,776.4 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөрт зарцуулаагүй үлдсэн 668.0 сая төгрөгийг буцаан татуулан хөтөлбөрийг 72.7%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

ХЭҮЗ-өөс 2016 онд ХБХЭУЧОХ-ийг батлахдаа ХУД, ЧД-т төсөв хуваарилаагүйгээс тус хөтөлбөр хэрэгжээгүй байна. Мөн 2020 онд НХЭГ, БГД, БХД, СБД-дэд хөтөлбөр хэрэгжээгүй шалтгаан нь ХЭҮЗ-өөс тухайн онуудад дээрх дүүргүүдэд төсөв хуваарилагдан ирээгүйгээс үүдэлтэй байна.

НХЭГ нь тухайн хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн болон давтан сургалт, үйлдвэр дээрх сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулахад 1,423.5 сая төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөл хөтөлбөрийн хүрээнд мэргэжлийн сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулж 7313 иргэнийг сургалтад хамруулснаас 1964 иргэн буюу 30.2% нь ажлын байраар хангагдсан байна.

Хүснэгт №28 НХЭГ-аас ХБХЭУЧОХ-т хамрагдсан иргэдийн судалгаа

№	Хамрагдах он	Зарцуулсан төсөв	Сургалтад хамрагдсан иргэдийн тоо	Ажлын байраар хангагдсан иргэн	Ажилд ороогүй иргэн
1	2016	227.8	2215	664	1551
2	2017	270.6	1716	1194	3206
3	2018	401.9	1628		
4	2019	183.8	1056		
5	2020	-	-	-	-
6	2021	113.6	698	352	346
Нийт		1197.7	7313	2210	5103

Тус хөтөлбөрийн хүрээнд сургалтын байгууллагаар дамжуулан сургалт зохион байгуулж байгаа боловч сургалтад хамрагдсан иргэд сургалтад зарцуулсан төсөв хамрагдсан иргэдэд дүн шинжилгээ хийхэд 69.8% ажлын байраар хангагдаагүй хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгүй байна. Энэ нь тухайн сургалтын байгууллагад санхүүжилтийг олгож ур чадвар олгох арга хэмжээ явуулж байгаа хэдий ч сургалтаас гарах үр дүнг тооцдоггүй, хяналт хэрэгжүүлдэггүй сургалтын байгууллагаас ирүүлж буй тайлан мэдээнд дүн шинжилгээ хийдэггүй байна.

7.Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр

Короновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг үзүүлж, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих иргэдийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тус хөтөлбөр хэрэгжжээ.

Цар тахлын үед хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар зохион байгуулсан байна.

Дүрслэл №9 ЦТҮААЭҮАСХ-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээ

ТХЭТББ чиглэлийн хүрээнд холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон ХЭҮЗ-өөс ажлын байрыг хадгалах цар тахлын нөлөөг багасгах чиглэлээр тус арга хэмжээг хэрэгжүүлжээ.

Тус хөтөлбөрт 2021 онд нийслэл болон дүүргийн хэмжээнд ХЭДС-аас 3,643.5 сая төгрөг батлагдаж, 2,848.8 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөрт зарцуулаагүй үлдсэн 797.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэн, хөтөлбөрийг 78.1%-ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.



Хүснэгт №29 ЦТҮААЭҮАСХ-т зарцуулсан хөрөнгө нийслэл, дүүргийн хэмжээнд 2021 он
/сая.төг/

Д/д	Дүүрэг нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн гүйцэтгэл /хувиар/
1	НХЭГ	442.0	14.7	427.3	3.3
2	БГД	357.4	300.7	56.7	84.1
3	БЗД	541.0	522.1	18.9	96.5
4	БНД	201.0	190.8	10.2	94.9
5	БХД	108.7	77.7	31.0	71.5
6	НД	315.1	201.0	114.1	63.8
7	СХД	632.8	608.0	24.8	96.1
8	СБД	302.9	207.4	95.5	68.5
9	ХУД	355.6	353.0	№2.6	99.3
10	ЧД	387.0	370.4	16.6	95.7
Нийт		3,643.5	2,845.8	797.7	78.1

НХЭГ нь тус хөтөлбөрийн хүрээнд дээрх үйл ажиллагаанд ХЭҮЗ-өөс 442.0 сая төгрөгийн төсөв батлагдан санхүүжилт олгосноос 14.7 сая төгрөгийг гудамж зам талбайн тохижилт, байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулсан ба үлдэгдэл 427.3 сая төгрөгийг буцаан төсөвт төвлөрүүлсэн байна. Энэ нь хэрэгжилт 3.3% буюу хангалтгүй, үр дүнгүй, 96.7%-ийг тухайн хөтөлбөрт зарцуулаагүй байна. Хуваарилсан төсвөөс 400.0 сая төгрөг нь малчдыг малжуулах арга хэмжээнд төсөвлөгдсөн нь хэрэгжээгүй байна. НХЭГ-аас Улаанбаатар хотод оршин сууж байгаад хөдөөд шилжин суурьшиж мал маллах хүсэлтэй өрхийн гэрээт малчнаар ажилд зуучилж, 2 жилийн хугацаанд тогтвортой ажлын байраар хангаж орлоготой болгох арга хэмжээний хүрээнд санхүүжилтийг олгосон боловч хэрэгжээгүй байна.

Дүгнэлт: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, санхүүжилтийг үр ашигтай зарцуулаагүйгээс үр дүнг бодитой тайлагнаж үнэлээгүй байна.

2.3 Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар зохих, үр дүнтэй арга хэмжээ авсан уу?

ТХЭТББ-ын 4 дэх хэсгийн 4.1.6-д ХБИ, эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар заажээ.

ХЭҮЗ-өөс аудитын хамрагдах хугацаа буюу 2016-2021 оны хэмжээнд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг батлан хэрэгжүүлээгүй хэдий ч 2022 оноос хөтөлбөр, арга хэмжээг батлан хэрэгжүүлж эхэлжээ.

ТХЭТББ-ыг хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээнд эмэгтэйчүүдийн хамрагдсан байдлыг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт №30 Нийслэл, дүүрэгт хэрэгжсэн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн хүйсийн байдал 2016-2021 он

/хүн.тоо/

Хэрэгжсэн хөтөлбөр	Нийт хамрагдсан иргэдийн тоо	Эмэгтэйчүүдийн эзлэх тоо /хувиар/	
		Тоо	Хувиар
Аж ахуй эрхлэх, бичил бизнесийг дэмжих хөтөлбөр	2561	1496	58.4
Нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөр	9115	5210	57.2
Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	43264	26717	61.8
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2072	1283	61.9
Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	65259	39533	60.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	10799	7023	65.0

Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	13499	9127	67.6
Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	313	131	41.9
Нийт	146882	90520	61.6

НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-т хэрэгжсэн нийт хөтөлбөрийн хүрээнд 2016-2021 онд 146882 иргэн хамрагдсанаас эдгээр иргэдийн 61.6% буюу 90520 нь эмэгтэй иргэд хамрагдсан байна. АБДХ нь бусад хөтөлбөрөөс хамгийн их иргэд хамрагдсан буюу 43264 иргэнээс 61.8% буюу 26717 нь эмэгтэй иргэд, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 313 иргэн хамрагдсанаас 41.9% буюу 131 эмэгтэй иргэд хамрагдсан байна.

НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2021 оны үйл ажиллагааны хөтөлбөр эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнес инкубатор төв” байгуулж, үйл ажиллагааг нь дэмжин гэж тусгажээ.

Энэхүү арга хэмжээний хүрээнд БНСУ-ын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-ын дэмжлэгтэйгээр НЗДТГ, Азийн сан хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнес инкубатор төв”-ийг 2017 онд байгуулж, үйл ажиллагаагаа тогтмолжуулан ажиллаж, тус төвөөр 4100 эмэгтэйчүүд бүртгэгдсэнээс давхардсан тоогоор 8000 гаруй удаагийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагаа, өдөрлөг арга хэмжээнд хамрагдаж, 80.0 мянган ам долларын бараа бүтээгдэхүүн борлуулсан байна.

Дүгнэлт: 2016-2021 онд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр бие даан хэрэгжээгүй ч бусад хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдаж буй иргэдийн дийлэнх хувь буюу 61,6% нь эмэгтэйчүүд хамрагджээ.

Б.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гийн хөрөнгийг хуулийн дагуу бүрэн төвлөрүүлж, үр дүнтэй зарцуулсан уу?

ХЭДТХ-ийн 21 дүгээр зүйлийн 21.1-д зааснаар ХЭДС нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор байгуулагдсан байна.

2016-2021 онд НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-т ХЭДС-аас 51,743.4 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 44,531.2 сая төгрөг буюу 86%-ийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулж 7,212.1 сая төгрөг буюу 14%-ийг буцаан төвлөрүүлж 165.5 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулжээ.

3.1 ХЭДС-ийн орлогыг хуульд заасны дагуу бүрэн төвлөрүүлсэн үү?

ХЭДТХ-ийн 22 дугаар зүйлд ХЭДС-ийн орлогыг дараах эх үүсвэрээр бүрдүүлэхээр заажээ. Үүнд:

- Улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүү;
- Гадаадын иргэнийг гэрээгээр ажиллуулсан ажил олгогчийн төлөх ажлын байрны төлбөр;
- Гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;
- Гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх төлбөр;
- Жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө;

- Бусад эх үүсвэр

Дээрх 9 үзүүлэлтээс дүүргүүдийн ХХҮХ нь ХБИ ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөр, жижиг зээл, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөгдсөн хөрөнгө, гадаад улс, ОУБ-аас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл зэрэг 3 үзүүлэлтээр орлогыг ХЭДС-д төвлөрүүлсэн байна. Төвлөрүүлсэн орлогыг дараах байдлаар харуулбал:

Хүснэгт №31 2016-2021 онд ХЭДС-д төвлөрүүлсэн орлого

/сая.төг/					
№	Дүүрэг	ХБИ ажиллуулаагүйн төлбөр	Гадаад улс, ОУБ-ын зээл, тусламж	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	ХЭДС-д төвлөрүүлсэн нийт орлого
1	БЗД	200.8	229.9	1,472.3	1,903.0
2	БГД	683.5	243.6	1,180.8	2,107.9
3	БНД	39.8	-	443.8	483.6
4	БХД	-	12.4	337.3	349.7
5	НД	34.2	-	531.6	565.8
6	СХД	61.4	168.9	125.1	355.4
7	СБД	7,120.2	70.5	886.8	8,077.5
8	ХУД	2,406.5	95.0	1,079.0	3,580.5
9	ЧД	1,959.7	74.1	787.2	2,821.0
Нийт		12,506.1	894.4	6,844.9	20,244.4

Дүүргүүдийн ХХҮХ нь хөгжлийн бэрхшээлтэй буюу одой иргэнийг ажиллуулаагүй ААНБ-аас 12,506.1 сая төгрөг, гадаад улс, ОУБ-ын зээл, тусламжаар 894.4 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтөөс 6,844.9 сая төгрөгийг төвлөрүүлж нийт 20,244.4 сая төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн байна.

ХЭДТХ-ийн 22 дугаар зүйлийн 22.1.2-д заасны дагуу орон нутгийн төсвөөс олгох хөрөнгөөс бүрдэх бөгөөд ЗГ-ын 2011 оны 375 дугаар тогтоолоор баталсан “ХЭДС-ийн хөрөнгийг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын 2.3⁴³-т заасны дагуу нийслэл, дүүргийн төсвийн орлогын тодорхой хувийг дэд санд төвлөрүүлэхээр хуульчилжээ. Гэвч нийслэл, дүүргийн төсөвт орон нутгийн төсвөөс орох орлогыг тусгаагүй, дэд сан байгуулаагүй байна.

Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийт төвлөрүүлсэн орлогын хамгийн өндөр буюу 61.8%-г ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлөх төлбөрийн орлого эзэлж байна.


Хөдөлмөрийн тухай хуулийн 111.1⁴⁴, 111.2⁴⁵-д хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй тохиолдолд тухайн ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө гэж заажээ.

⁴³ “Орон нутгийн төсвөөс хуваарилах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, дэд санд төвлөрүүлнэ.

⁴⁴ 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна.

⁴⁵ Аж ахуйн нэгж, байгууллага энэ хуулийн 111.1-д заасан хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд сар бүр төлбөр төлнө.

График №5: ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлсөн төлбөр



Энэхүү графикаас харахад дараах 3 дүүргүүдийн ХХҮХ буюу СБД 57%, ХУД 19%, ЧД 16%-ийг ХБИ-ийг ажиллуулаагүй ААНБ-аас төлбөрийг бүрдүүлсэн байна. Энэ нь тухайн дүүргийн газар нутгийн байршил хүн ам, нягтаршил зэргээс хамаарч гадаадын хөрөнгө оруулалттай болон дотоодын ААНБ-ууд үйл

ажиллагаагаа төвлөрөн явуулдагтай холбоотой байна. Харин алслагдсан болон захын дүүргүүдэд үйл ажиллагаа явуулдаг ААНБ-ын тоо бага байгаатай холбогдуулан орлого бүрдүүлэлт бага хувьтай байна.

Дүгнэлт: 2016-2021 онд дүүргүүдийн ХХҮХ нь ХЭДС-т нийт 20,244.4 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэн ажилласан боловч нийслэл, дүүргийн төсөвт орон нутгийн төсвөөс орох орлогыг тусгаагүй, дэд сан байгуулаагүй байна.

3.2 ХЭДС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулж, үр нөлөөг тооцсон уу?

Нийслэл, дүүргүүдийн ХХҮХ-ийн хэмжээнд 2016-2021 онд ХЭДС-аас 51,743.4 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 44,531.2 сая төгрөг буюу 86%-ийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулж 7,219.1 сая буюу 14% төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт № 32 ХЭДС-ийн санхүүжилт, зарцуулалт 2016-2021

№	Нийслэл, дүүргийн нэр	Санхүүжилт	Зарцуулалт	/сая.төг/ Буцаан төвлөрүүлсэн
1	НХЭГ	7,243.2	6,442.5	800.7
2	БНД	2,534.8	1,668.6	866.2
3	БХД	1,492.3	1,192.2	300.1
4	БГД	5,577.0	5,075.6	501.4
5	БЗД	8,941.5	8,159.1	782.4
6	НД	2,667.0	1,948.5	718.5
7	СХД	7,729.2	7,029.0	700.2
8	СБД	5,297.1	4,052.5	1,244.6
9	ХУД	5,010.8	4,392.6	618.2
10	ЧД	5,250.5	4,570.7	679.8
Нийт		51,743.4	44,531.3	7,212.1

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс батлагдан ирсэн төсвийн зарцуулалтад цаглаварт хугацааны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийгдэж зөвлөмж, дүгнэлтийг өгч ажиллажээ.

Дүүргүүд нь хөтөлбөр арга хэмжээнд дотоод мониторинг хяналт шалгалт хийж хэрэгжүүлдэг хэдий ч төсвийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хийж, хэрэгжүүлдэггүй байна. Тухайлбал:

Тайлангийн АМЧБО, АБДХ, Ажилд зуучлах үйлчилгээ, ХБИХЭДХ-үүдэд гарсан нийт 165.5 сая төгрөгийн зөрчлүүдийг тусгасан. Энэ нь ХЭДТХ-ийн 23 дугаар

зүйлийн 23.3⁴⁶-т заасныг мөн Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2⁴⁷, 16 дугаар зүйлийн 16.5.5⁴⁸-т заасныг тус тус зөрчжээ. Мөн 2017-2021 онд ХЭСЗ-ийн бүрэлдэхүүнд дүрэмд зааснаас өөр албан хаагчийг НХЭГ болон БНД, БГД-үүд ажиллуулж 2.1 сая төгрөгийн урамшуулал олгосон нь ХЭДТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.7⁴⁹-д болон “Хөдөлмөр эрхлэлтийн аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн дүрэм”-ийн 3.1⁵⁰-т т заасны дагуу нийслэл болон дүүргүүдийн салбар зөвлөлийн гишүүдийг баталж ажиллахаар заасныг зөрчсөн байна.

/Зориулалт бусаар зарцуулсан 165.5 сая, ХЭСЗ-ийн урамшууллын 2.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж, акт, албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв./

Дүгнэлт: ХЭДС-аас 51,743.4 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 44,531.2 сая төгрөг буюу 86%-ийг төсөл хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулж 7,219.1 сая төгрөг буюу 14%-ийг буцаан төвлөрүүлж 165.5 сая төгрөгийг зориулалтын бусаар зарцуулжээ.

Б.4. Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан (МБСДС) болон Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас хөдөлмөрт бэлтгэх үйл ажиллагаа үр нөлөөтэй хэрэгжсэн үү?

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа, санхүүжилт, гүйцэтгэлд нь ХНХЯ, БШУЯ-аас арга зүй, удирдлагаар хангаж, хяналт хэрэгжүүлдэг тул тухайн үйл ажиллагаа Нийслэл, дүүргийн хэмжээнд хамрах хүрээнд ороогүй болно.

Б.5. "Ковид-19" цар тахлын үед хөдөлмөр эрхлэлтийн талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар УОК, ЗГ-аас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, НОК-оос гарч буй тогтоол шийдвэрүүдийн дагуу НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс цар тахлын үед ажлын байрыг хадгалах чиглэлээр цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хүндрэл бэрхшээлийн талаар судалгааг гарган авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

5.1 Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

УОК, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 27, 45, 91 дүгээр тогтоол, НОК, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/06, А/87, А/108, А/161, А/265, А/431 дугаар захирамжаар гарч буй удаа дараагийн шийдвэрүүдийг НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь тухай бүр хэрэгжүүлэн ажиллажээ.

Монгол Улсын Засгийн газраас 2020 онд цар тахлын үед эдийн засгийн хүндрэлийг даван туулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- 2020 оны 04 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 01 хүртэл аж ахуйн нэгжүүдийн нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэж, цалин хөлснөөс орлогын албан татвар суутгахгүй, 1.5 тэрбумаас доош орлоготой ААН-ээс татвар авахгүй байх ажлын байрыг хадгалж буй хувийн ААНБ-дад гурван сарын хугацаанд сар бүр 200,000 төгрөгийн дэмжлэг олгохоор шийдвэрлэсэн.

⁴⁶ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

⁴⁷ төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх

⁴⁸ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴⁹ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн гишүүнээр хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын дарга, ажилтныг оруулахыг хориглоно.

⁵⁰ Зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор тухайн аймаг, нийслэл, дүүргийн засаг дарга байх бөгөөд 3 талын төлөөлөгчийн тоо адил байна.

- 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэл хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж байгууллагыг алданги торгуулиас чөлөөлнө.
- 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэл худалдааны төв болон үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээсэлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон түрээсийн баримтаар нотлогдсон тохиолдолд, бууруулсан хувь хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах ААНОАТ-аас хөнгөлнө.
- Айл өрх, ААНБ-ын цахилгаан, ус дулааны төлбөрийг тэглэсэн.

Дүгнэлт: Цар тахлын үед ажлын байрыг хадгалах талаар УОК, ЗГ-аас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, НОК-оос гарч буй тогтоол шийдвэрүүдийн дагуу хэрэгжилтийг тухай бүр хэрэгжүүлэн ажиллажээ.

5.2 Цар тахлын үед ажилтныг дэмжих чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байсан уу?

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 04 сарын 09-ны өдрийн 21 дугаар тогтоолоор Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай тогтоолын 3 дах хэсэгт ажлын байрыг хадгалах багц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүний хүрээнд цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалах зорилгоор 2020 оны 04 сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд даатгуулагчаас бусад даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод ногдуулсан ажил олгогч болон даатгуулагчийн төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх шийдвэр гаргаж хэрэгжүүлснийг УОК, НОК-оос хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Мөн 0-5 настай хүүхэдтэй эмэгтэйчүүдийг цар тахлын үед цахимаар ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж ажилтныг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.

Дүгнэлт: НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ээс цар тахлын үед ажлын байрыг хадгалах чиглэлээр ЗГ-аас авч буй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ.

5.3 Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ үр дүнтэй байна уу?

Ковид-19" цар тахлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдлын үед үйл ажиллагаа эрхэлж байгаа болон үйл ажиллагаа нь зогссон ААНБ-ын нөхцөл байдлын талаарх судалгааг НХЭГ-аас 2021 онд хийжээ. Тус судалгааг цар тахлын үеийн сөрөг нөлөөлөл нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон ажиллагсдын судалгаа, үйл ажиллагаа нь зогссон ахуйн үйлчилгээний салбарын судалгаа болон ААНБ, холбоодод тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судлах чиглэлээр арга хэмжээг авч ажиллажээ. Энэхүү судалгааны хүрээнд:

Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын мэдээллийн саналыг авч дүн шинжилгээ хийж нэгтгэжээ. Арга хэмжээний хүрээнд НХЭГ-аас дараах саналыг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

- 2021 оны 07 дугаар сарын 01 хүртэл түрээсийн төлбөрийн 50% бууруулах;

- Гадаадын мэргэжилтэн ажиллуулж байгаа зочид буудлууд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл авахын тулд 1 гадаад иргэнд сард 862.0 мянган төгрөгийн төлбөр төлдөг. Тус төлбөрөөс чөлөөлүүлэх;
- Нийгмийн даатгалын сангаас ААНБ-д олгож байсан 200.0 мянган төгрөгийн дэмжлэгийг хилийн хорио цээр цуцлагдтал үргэлжлүүлэн олгох;
- Үйл ажиллагаа нь зогссон ААНБ-д сүүлийн 3 жилийн дундаж орлогын 1 жилд ногдох орлогын 10-20%-тай тэнцэх нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх;
- Үйл ажиллагаа нь зогссон иргэдэд 840.0 мянган (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлж) төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгох чиглэлээр арга хэмжээг авч ажиллах саналыг хүргүүлсэн байна.

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ нь цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс үүдэн ажилгүй болсон иргэдийн судалгаа, саналтай холбоотой бие даасан арга хэмжээ хэрэгжүүлээгүй.

Дүгнэлт: Цар тахлын үеийн сөрөг нөлөөллөөс зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг хамгаалах чиглэлээр хүндрэл бэрхшээлийн талаар судалгааг гарган авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан байна.

5.4 Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг үнэн бодитой гаргасан уу?


НХЭГ-аас “Ковид-19” цар тахлын үед Нийслэлд бүртгэлтэй ААНБ-ын тоо, түүнээс үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын мэдээллийг Нийслэлийн статистикийн газрын тоон мэдээлэл дээр үндэслэн гаргасан бөгөөд үйл ажиллагаа нь зогссон аж ахуйн нэгжүүдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, саналыг тодорхойлсон байна.

Хүснэгт №33 Нийслэлд бүртгэлтэй ААНБ-ын тоог үйл ажиллагаа эрхлэлтийн байдлаар авч үзвэл:

Дүүрэг	Бүгд	Үйл ажиллагаа явуулж байгаа	Үйл ажиллагаа явуулаагүй	Үйл ажиллагаа зогсоосон шалтгаан			
				Үйл ажиллагаа эхлээгүй байгаа	Үйл ажиллагаа түр зогсоосон	Үйл ажиллагаа бүрэн зогсоосон	Бусад
БНД	963	506	457	201	212	38	6
БЗД	40808	15010	25798	13759	11748	168	123
НД	1586	752	834	404	368	56	6
СХД	20665	7571	13094	7776	4791	379	148
СБД	32529	14197	18332	10249	7043	356	684
ХУД	23684	7863	15821	11211	3810	464	336
ЧД	20103	7535	12568	4661	7518	213	176
БХД	170	80	90	31	33	26	0
БГД	35086	13347	21739	12380	8477	319	563
Нийт	175594	66861	108773	60672	44000	2019	2042

Мэдээллийн эх үүсвэр: Нийслэлийн Статистикийн газар 2021 он

График №6 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, ААНБ-ийг салбар, дүүргээр нь авч үзвэл:



Дүгнэлт: Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарсан өөрчлөлт, статистик тоо мэдээг гарган ажиллажээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

1. Төрөөс хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь хөгжлийн бодлого чиглэлийн урт болон дунд хугацааны баримт бичигтэй уялдаж байгаа хэдий ч нийслэлд богино хугацааны бодлогын баримт бичиг батлуулаагүй, бодлогын баримт бичиг боловсруулахад бүх талын оролцоо бүрэн хангагдахгүй байна.
2. Бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох үзүүлэлтийг харгалзаагүй, бодит тооцоололд үндэслээгүй байна.
3. Нийслэл, дүүргүүдийн ХЭСЗ нь дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн салбарын түвшиний харилцаа, хамтын ажиллагаа хангалтгүй байна.
4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ орон нутгийн онцлогт тохирсон зохицуулалт, хяналтын арга хэмжээг авч ажиллаагүй, шалгарсан төслийн хэрэгжилт, үр дүн муутай байна.
5. Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээнд хамаарах АМЧБО, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, ажилд зуучлах арга хэмжээний хэрэгжилт, үр дүн муутай, нэгдсэн бүртгэл, мэдээллийн системийн ашиглалт хангалтгүйгээс тоо мэдээ зөрүүтэй, программ хангамж нь бодит хэрэгцээ шаардлагыг хангахгүй байна.
6. Холбогдох байгууллагуудаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шалгалтыг бүрэн хийгээгүйгээс үр нөлөө муутай байна.
7. Нийслэл, дүүргийн хэмжээнд төрөөс хэрэгжүүлж буй бодлого, зорилтыг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс ХЭДС-д хөрөнгө баталдаггүй, дэд сан байгуулаагүй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэх арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч үр дүн муутай байна.
8. ХЭҮЗ-өөс батлан хэрэгжүүлж байгаа тогтоол шийдвэр, журамд жил бүр өөрчлөлт хийсэн эргэж буцсан шийдвэрүүдээс үүдэж чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл дүүргүүдийн ХХҮХ-т бий болсон байна.
9. 2016-2021 онд дүүргүүдийн ХХҮХ нь ХЭДС-д нийт 20,245.5 сая төгрөгийн төсвийг бүрдүүлэн ажилласан.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Ж.Батбаясгалан/-д

1. Нийслэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөртэй уялдуулан тодорхой бодлого тодорхойлж, санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцон нийслэлийн төсөвт тусгаж, төсвийн гүйцэтгэлд хяналт хийх.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагч /Д.Сумъяабазар/-д:

1. Нийслэлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой бодлого боловсруулж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, нийслэлийн төсөвт тусгуулах.
2. Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.
3. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг тогтмол хэрэгжүүлж, үр дүнг тооцож байх.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар /С.Нямдорж/-д:

1. Хөдөлмөр эрхлэлтийн бодлого чиглэлийг хэрэгжүүлж байгаа шат шатны байгууллагуудтай харилцан уялдаатай байх талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
2. Мэргэжлийн боловсрол сургалтын төвүүдийн сургалтын үйл ажиллагаанд хяналт хийж, үр дүнг бодитоор тооцож санхүүжилтийг олгох.
3. Хөдөлмөрийн эрэлт нийлүүлэлтийн судалгааг бодитоор гаргаж, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх.

Дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга, хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга нар

1. ХЭҮЗ-ийн тогтоолоор батлагдсан салбар зөвлөлийн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах.
2. Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нэгдсэн сан бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг бодитоор тооцож тайлагнах.
3. Хөтөлбөр арга хэмжээнд батлагдан ирсэн төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг бодитоор тайлагнаж, биелэлтийг тооцох.
4. Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээний хүрээнд хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлийг барагдуулах талаар шат дараатай арга хэмжээг авч ажиллах.
5. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний хүрээнд иргэдээс ирүүлж буй төслийг сонгон шалгаруулахдаа тухайн төслийн хэрэгжих боломжийг харгалзан үзэх.
6. АМЧБО, зуучлах үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлж зорилтот бүлгийн иргэдийг хамруулах, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлэх, тайлан мэдээг бодитоор үнэлж дүгнэх.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД /"ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР"-аар уламжлуулан хүргүүлэх/

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд шаардагдах хөрөнгийг батлахдаа НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-ээс ирүүлсэн төсөвт тусгуулах санал болон орон нутгийн онцлог, бодит гүйцэтгэлд үндэслэн хуваарилалтыг хийх;
2. ХЭҮЗ-өөс батлан хэрэгжүүлж байгаа бодлого, тогтоол шийдвэр, дүрэм журамд жил бүр өөрчлөлт хийгдэж, хөтөлбөрийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж, чанаргүй буюу хугацаа хэтэрсэн зээл дүүргүүдийн ХХҮХ-дэд бий болсон байдалд анхаарч ажиллах;
3. Хөтөлбөр, төсөл арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг олгох, сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтийг журам заавартай болгох;
4. Нийслэл, дүүргүүдийн салбар зөвлөл болон НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-ийн дүрэм чиг үүргийн харилцан уялдааг сайжруулж, үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.

Холбогдох байгууллагын санал


МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас: (976-11) 32-71-69, Факс: (976-11) 32-21-47
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022.05.03 № 02-01/480
Танай 2022.04.28-ны № 889 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд танилцлаа.

Аудитын дүгнэлт, зөвлөмжийн хүрээнд саналгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭДИЙН
ЗАСГИЙН ХӨГЖИД ТӨР, ХУВИЙН
ХЭВШЛИЙН ТҮНИШЛЭЛИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ  Ж.САНДАГСҮРЭН

111020069669



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ГАЗАР
Нийслэлийн Өмчийн I байр,
Совлын төв өргөө "Г" корпус,
Г.Амарын гудамж, 8 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 97 52
Цахим хуудас www.ubbirj.ub.gov.mn

2022.04.29 № 120
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд тусгах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.




НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
Д.Нацагдоржийн гудамж, 1 дүгээр хороо,
Багануур дүүрэг, Улаанбаатар хот, 12090
Утас/Факс: (976) 7021-2322
E-mail: info@baganuur.hudulmur-halamj.gov.mn
http://www.baganuur.hudulmur-halamj.gov.mn

2022.05.02 № 167
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцсан болно.

 Багануур Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
Удирдлага
Даргын Албан Түр Орлон Гүйцэтгэгч
Содномдорж Ичинхорлоо
2022.05.02 14:44


НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
Өндөр толгой, 1 дүгээр хороо,
Багахангай дүүрэг, Улаанбаатар хот, 12330
Утас: (976) 7049 1181, 7049 1182
Цахим шуудан: info@bagakhangai.hudulmur-halamj.gov.mn

2022.04.29 № 170
танай 2022.04.26 -ны № 886 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын АГГ-2022/20-ШТА-ГА тайлангийн төсөлд танилцлаа. Тус тайлангийн төсөлд тусгах санал байхгүй болно.

 Багахангай Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
Захиргаа Хяналтын Алба
Хэлтсийн Дарга
Долгоруудан Энхтайван
2022.04.29 16:13




НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
6 дугаар хороо, Бага тойруу, 15140
Утас/факс: (976-11) 32-11-39
E-mail: info@chingeltei.hudulmur-halamj.gov.mn
http://www.chingeltei.hudulmur-halamj.gov.mn

2022.05.04 № 608
танай -ны № -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА М.ЭРДЭНЭЖАРГАЛ ТАНАА

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын АГГ-2022/20-ШТА-ГА тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлд тусгах саналгүй.



Чингэлтэй Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
Удирдлага
Хэлтсийн Дарга
Адъяабазар Сэрээтэр
2022.05.04 17:29




НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

То вангийн гудамж 22/1,19 хороолол
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17031
Утас: (976-11) 34 51 53
Цахим шуудан: info@han-uul.hudulmur-halamj.gov.mn
Цахим хуудас: /www.han-uul.hudulmur-halamj.gov.mn

2022.05.03 № 252
танай 2022.04.26 -ны № 886 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын АГГ-2022/20-ШТА-ГА тайлангийн төсөлтэй танилцлаа. Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.



Нийслэлийн Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтэс
Удирдлага
Хэлтсийн Даргын Үүргийг Түр Орлон Гүйцэтгэгч
Падернов Амарлувшин
2022.05.03 10:22




НИЙСЛЭЛИЙН НАЛАЙХ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Д.Даваажав 17, 2 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот, 12790
Утас: (976) 7023 3260
Цахим шуудан: info@nalaikh.hudulmur-halamj.gov.mn
Цахим хуудас: www.nalaikh.hudulmur-halamj.gov.mn

2022.05.03 № 192
танай 2022.04.26 -ны № 886 -т

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайланд тусгах саналгүй болно.



Налайх Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
Удирдлага
Даргын Албан Үүргийг Түр Орлон Гүйцэтгэгч
Бямбажав Энхтөгс
2022.05.03 18:29



НИЙСЛЭЛИЙН СӨНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Тоготомь гудамж, 6 дугаар хороо,
Сонгинохайрхан дүүрэг,
Улаанбаатар хот, 16065-0016
Утас/факс: (976) 70134408
Цахим шуудан: info@snginokhairkhan.gov.mn
Цахим хуудас: www.snginokhairkhan.gov.mn

2022.05.04 № 543
танай -ны № -т

Тайлбар, санал хүргүүлэх тухай

Тус дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2016-2021 оны гүйцэтгэлийн үр дүнд хийсэн аудитын шалгалтад холбогдох тайлбар, саналыг хүргүүлж байна.


Сонгинохайрхан дүүрэг нь Орон нутгийн онцлог хэрэгцээнд тохирсон санхүүгийн дэмжлэгийг 2018 онд хэрэгжүүлэн 4 иргэнд 200.000.000 (хоёр зуун сая) төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон боловч 2022 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар 34.900.000 (гурчин дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэн 165.100.000 (нэг зуун жаран таван сая нэг зуун мянга) төгрөгийн хугацаа хэтрэлттэй бөгөөд эдгээр 4 иргэний шүүхийн байгууллагад шилжүүлэн тодорхой заасан хугацаанд буцаан төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан.

Гэвч заасан хугацаанд төлөлт хийгдээгүй тул дараагийн шатны арга хэмжээг авч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн албадан төлүүлэх арга хэмжээг аван ажиллаж байна. /Холбогдох баримтыг хавсралтаар хүргүүлнэ/

2020 онд "Хөгжлийн барихээлтэй иргэний ажлын байрыг дэмжих" хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт 67 иргэний 140.000.000 (нэг зуун дөчин сая) төгрөгийг олгохдоо сонгон шалгаруулалт хийх ажлын хэсэг Хөдөлмөр эрхлэлтийн албаны даргаар ахлуулсан 5 гишүүнтэй сонгон шалгаруулалт хийн хурлын тэмдэглэл хөтөлсөн байгаа тул холбогдох баримтыг хүргүүлж байна.

1 дүгээр хавсралт: Хурлын тэмдэглэл, 25 хуудастай.

2 дугаар хавсралт: 4 иргэний шүүхийн байгууллагад шилжүүлсэн тухай, 4 хуудастай.



Сонгинохайрхан Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс
Захирааг Хяналтын Алба
Захирааг Хяналтын Албаны Дарга
Хүлбэлтэр Унраа
2022.05.04 10:17



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Мөнхтөв, Баянзүрх дүүргийн
5 дугаар хороо, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 15341-0014

Утас: (976) 7708 1220

Цахим хуудас: info@bayanzurkh.hudulmur-halamj.gov.mn

Цахим хаяг: www.bayanzurkh.hudulmur-halamj.gov.mn

2022.05.03

№

350

талай

№

3

Санал хүргүүлэх тухай

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Ажилд зуучлалын зардлыг гаргахдаа хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нарт зориулж бичгийн цаас, принтерийн хор зэрэг зарцуулах зайлшгүй шаардлага байдаг.

Хороо хариуцсан мэргэжилтнүүд ажил олгогч байгууллагуудаас шинээр бий болсон ажлын талаарх мэдээллийг цаасан хэлбэрээр маягт хэвлэж бөглүүлж авч бүртгэх, мөн сул чөлөөтэй ажлын байрны захиалга авах, ажлын байрны зарыг олон нийтэд мэдээлэх, зарыг хэвлэж мэдээллийн самбар болон хэсгийн ажлагч нарт хэвлэж тараах зэрэг ажлыг хийж гүйцэтгэхэд бичгийн цаас, принтерийн хор гэх мэт бичиг хэргийн зардлууд зайлшгүй шаардлагатай байдаг. Бичиг хэргийн зардлыг дүн үйл ажиллагаанаас гаргахад хүрэлцдэггүй учир ажилд зуучлах зардлаас гаргаж хорооны хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт өгдөг.

2018 онд Орон нутгийн онцлогт тохирсон зорилтот төслөөр 6 иргэн, 6 байгууллагад 1 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосноос 1 иргэн, 2 байгууллага нь зээлээ бүрэн төлж барагдуулсан. Санхүүгийн дэмжлэг авсан иргэд, байгууллагуудтай байнга холбогдож зээлийн эргэн төлөлтөө барагдуулахыг шаарддаг. Санхүүгийн дэмжлэгийн хугацаа дууссан иргэдийг шүүхийн байгууллагад шигжүүлэхээр ажиллаж байна. Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгийг олгоход Монгол банкны зээлийн сантай холбогдож банкны зээлгүй иргэдэд олгож байвал иргэдийн буцаан төлөх чадвар илүү байх болно.

Бад Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Хэлтэс

Баянзүрх Дүүргийн Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс

Дарга

Л.Павласүрэн Цолмонгэрэл

2022.05.03 14:53



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН АУДИТЫН III ХЭЛТЭСТ

НИЙСЛЭЛИЙН СУХБААТАР ДҮҮРГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Дөнөөрийн гудамж, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14180-0069

Утас: (976-11) 35 05 77

Цахим хуудас: info@std.hudulmur-halamj.gov.mn

Цахим хуудас: www.std.hudulmur-halamj.gov.mn

2022.05.03

№

14418

талай

№

886

Санал хүргүүлэх тухай

"Төрөөс хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилт үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын (АГТ-2022/20-ГТА-ГА) тайлангийн төсөлд тус хэлтсээс дараах саналыг хүргүүлж байна.

2019 онд хэрэгжсэн "Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл"-ийн хүрээнд 9 иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэгийг 2019 оны 12 дугаар сарын 24, 26-ны өдөр гэрээ байгуулан олгосон бөгөөд гэрээний хугацаа 2022 оны 12 дугаар сарын 24, 26-ны өдөр дуусна.

Гэрээний хугацаа дуусаагүй боловч эргэн төлөлтийнхөө хуваарийн дагуу эргэн төлөлтөө хийхгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжид 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 2/223, 2/224, 2/225, 2/226, 2/227, 2/228, 2/231, 2/232, 2/233 тоот албан бичгээр мэдэгдэл хүргүүлж, уулзалт хийж, хариу тайлбар бичгээр авсан.

Энэхүү төслийн хэрэгжилт ковид-19 цар тахалтай давхацсан тул эргэн төлөлтийн хувь, хэмжээ бага болсон.

Иймд гүйцэтгэлийн аудитын тайланд "Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл"-ийн хэсэгт тус дүүргийн гэрээний хугацаа дуусаагүй байгаа талаар оруулж өгнө үү.

Сүхбаатар Дүүргийн Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Хэлтэс

Удирдлага

Калтсийн Дарга

Мачалова Олгонтуяа

2022.05.03 15:23

АГТ-2022/20-ШТА-ГА

54

Саналд өгсөн тайлбар

Аудитын тайлангийн төсөлд Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд НЗДТГ, НХЭГ болон дүүргүүдийн ХХҮХ-ээс 2022 оны 5 дугаар сарын 5-ны дотор албан бичгээр санал ирүүлсэн бөгөөд зарчмын зөрүүтэй санал ирээгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй болно гэж үзлээ.

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт

№	НЗД бөгөөд УБ хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Биелэлт		Хэрэгжсэн хувь
	Заалтын дугаар, утга		Заалтын дугаар, утга		
1	4.7	Нийслэлийн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог хангах , зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.			87.6%
2	4.7.1	Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг 60 хувьд хүргэнэ.	4.7.1	Нийслэлийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2016 онд 47,4%, 2017 онд 48,7%, 2019 онд 49,4%	48.5%
3	4.7.2	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Нэг өрх-Нэг ажлын байр”, “ Тогтмол орлого-тогтвортой амьдрал” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.	4.7.2	42 байгууллага, албан тушаалтны 100 гаруй санал тусган боловсруулж НИХТ-ийн 2017 оны 71 дүгээр тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөөг нийслэлийн засаг даргын 2017 оны А/553 дугаар захирамжаар батлуулсан.	100%
4	4.7.3	Шинэ ажлын байр бий болгосон, ажлын байр нэмэгдүүлсэн ажил олгогчдыг дэмжих урамшууллын систем бий болгоно.	4.7.3	“Ажил олгогчийг дэмжин урамшуулах журам” боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ч нийгмийн хамгааллын багц хууль, татварын тухай хуулийн заалттай зөрчилдсөн хэрэгжээгүй	70%
5	4.7.4	Мэргэжилтэй ажиллах хүчин бэлтгэх тогтолцоог бэхжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн 50000-аас доошгүй ажиллах хүчин бэлтгэнэ.	4.7.4	2016-2019 онд 41,6 мянга гаруй иргэнийг мэргэжлийн ур чадвар олгох мэргэшүүлэх сургалтад хамруулсан.	70%
6	4.7.5	Нийслэлийн “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих төв” байгуулж, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг дэмжин, ажил олгогч, ажил хайгч иргэдэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг нэг цэгээс үзүүлнэ.	4.7.5	“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг 2018 онд байгуулсан. Төв нь MNS:6620-2016 шаардлага ханган ажиллаж, №2018/ТУ31 бүртгэлийн гэрчилгээ авсан.	100%
7	4.7.6	Оюутан залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих “Орлоготой оюутан” хөтөлбөр хэрэгжүүлж, суралцах хугацаандаа хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй болгоно.	4.7.6	Нийт 52,5 мянган оюутан залуусыг бүртгэсэн. 73,0% буюу 38,8 мянган иргэнийг цагийн ажилд зуучилсан.	100%
8	4.7.7	“Итгэлийн зээл” үндэсний хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж жижиг, дунд үйлдвэрлэл, өрхийн байгуулж аж ахуй, бичил бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.	4.7.7	“Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийг НИТХ-ын 2014 оны 17/16 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Нийслэлийн 150 хороонд байгуулагдсан 123 хадгаламж зээлийн хоршоогоор 3479 төсөлд нийт 14,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн сангаас олгосон санхүүжилтийг буцаан төвлөрүүлэх тухай” 2017 оны 05 дугаар тогтоолын дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн төсөвт 5,7 тэрбум төгрөг буюу нийт санхүүжилтийн 39,0%-ийг эргэн төвлөрүүлсэн байна.	100%
9	4.7.8	“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн инкубатор төв” байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.	4.7.8	“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнес инкубатор төв”-ийг 2017 онд байгуулсан.	100%
10	4.7.9	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хэрэгжүүлэн, түр болон байнгын ажлын байраар хангана.	4.7.8	“ Залуучуудын хөдөлмөр, эрхлэлт гарааны бизнесийг дэмжих” хөтөлбөрийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж 186 иргэнд 540 сая төгрөгийн дэмжлэг олгосон.	100%

НХЭГ, дүүргүүдийн ХХҮХ-д 2016-2020 онд ОУБ-аас санхүүжсэн төсөл арга хэмжээ

/сая.төг/								
Д/д	Дүүргийн нэр	Хэрэгсжсэн он	Хэрэгжсэн төсөл, хөтөлбөр	Олон улсын байгууллагын санхүүжилтээр	Хэрэгжүүлсэн байгууллага	Олгосон санхүүжилт	Хэрэгжилт	Биелэлт хувиар
1	БГД	2020	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр - Ажлын туршлага эзэмшүүлэх Интерншип хөтөлбөр	Дэлхийн банк	БГД ХХҮХ	137.3	40.7	29.7
		2021	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр - Ажлын туршлага эзэмшүүлэх Интерншип хөтөлбөр	Дэлхийн банк	БГД ХХҮХ	106.3	90.9	85.5
2	БЗД	2021		Швейцарын хөгжлийн агентлаг	БЗД ХХҮХ	8.0	8.0	100.0
3	БНД	2020	ХЗЗ-ийг туршилтын хөтөлбөрийн Орон нутгийн санаачилгын төсөл	Дэлхийн банк	БНД ХХҮХ	61.4	18.2	29.6
		2021	ХЗЗ-ийг туршилтын хөтөлбөрийн Орон нутгийн санаачилгын төсөл	Дэлхийн банк	БНД ХХҮХ	62.2	43.0	69.1
		2021	Зах зээлийн судалгааны төсөл	Швейцарын хөгжлийн агентлаг	БНД ХХҮХ	8.0	8.0	100.0
4	БХД	2021	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банкны төслийн санхүүжилт	ХНХЯ, ХХҮЕГ	73.1	35.1	48.0
		2021	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Швейцарын хөгжлийн агентлаг	ХНХЯ, ХХҮЕГ	25.5	25.5	100.0
5	НД	2020	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банкны төслийн санхүүжилт	ХНХЯ, ХХҮЕГ	19.1	3.6	18.8
6	СБД	2020	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банк	“За нэгдэл” ТББ-ын дэргэдэх Гэгээн мэргэжлийн сургалтын төв	2.0	2.0	100.0
		2021	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банк	“Алтан алхам” ТББ-ын дэргэдэх сургалтын төв	4.7	4.7	100.0
		2021	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв,	Швейцарын Хөгжлийн Агентлаг	GFA Консалтинг групп	26.4	26.4	100.0
7	СХД	2020	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банк	СХД Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв.	21.6	21.6	100.0
		2020	Ажил мэргэжлийн төв	Дэлхийн банк	Койт трейд ХХК	112.6	112.6	100.0
		2021	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банкны санхүүжилтээр	Алтан Алхам ТББ	9.3	9.3	100.0

		2021	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв,	Швейцарын Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр	Койт трейд ХХК	41.0	41.0	100.0
8	ХУД	2020	Орон нутгийн оролцоо, санаачилгатай, онцлогт тохирсон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүдийн ХЭДТ-ын хөтөлбөр	Дэлхийн банкны санхүүжилттэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр	Хан-Уул ХХҮХ	95.0	95.0	100.0
		2021	Орон нутгийн оролцоо, санаачилгатай, онцлогт тохирсон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банкны санхүүжилттэй ХЭДТ-ын хөтөлбөр	Хан-Уул ХХҮХ	55.6	55.6	100.0
9	ЧД	2020	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банк	ХНХЯ	62.3	14.4	23.1
		2021	ХЗЗ-ийг дэмжих туршилтын хөтөлбөр	Дэлхийн банк	ХНХЯ	11.9	11.9	100.0
10	НХЭГ	2021	Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн төсөл	Швейцарын Хөгжлийн Агентлаг	НХЭГ	22.1	22.1	100.0
Нийт						965.4	689.6	71.4

Хавсралт 3

Нийслэл, дүүргүүдийн ХЭСЗ-ийн дүрмийн хэрэгжилт 2016-2021

	Он	ХЭ-ийг дэмжих зориулалтаар зарцуулагдах хөрөнгийг аймаг, нийслэл, дүүргийн төсөвт жил тусган баталгаажуулах	ХЭ-ийн талаар баримтлах бодлого, холбогдох хөтөлбөрүүд, ХЭДС болон аймаг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх орон нутгийн онцлогтой хөтөлбөрийг боловсруулан батлуулах ажлыг санаачлан зохион байгуулах	ХЭД дэд сангийн орлого, зарлагын явц, байдал, ХЭДС-ийн жижиг зээлийн эргэн төлөлтийн байдалд хяналт тавих	Тухайн орон нутагт хэрэгжсэн ХЭД үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөр төслийн үр дүн нөлөөлөлд жил бүр үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах	ХЗЗ-ийн эрэлт, нийлүүлэлт болон үр дүнгийн судалгааг тодорхой давтамжтайгаар МБС-ийн байгууллагуудтай хамтраг хийж, хэрэглэгчид, үйлчлүүлэгчдийг зах зээлд эрэлттэй болон илүүдэлтэй талаарх мэдээллээр хангах	ХЭ-ийн асуудлаар төрийн захиргааны үйлчилгээний байгууллага, ялангуяа МБС, ЖДҮ, ХАА, гэр бүл залуучууд хөгжлийн болон бусад холбогдох асуудал эрхэлсэн байгууллага, бусад хороо зөвлөлүүдтэй үйл ажиллагаа уялдуулах	Тухайн орон нутагт хэрэгжсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүн болон нөлөөлөлд хийсэн үнэлгээний тайланг ХЭҮЗ-д жил бүр ирүүлэх
НХЭГ	2016	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
	2017	тийм	тийм	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй
	2018	тийм	тийм	үгүй	үгүй	тийм	үгүй	үгүй
	2019	тийм	тийм	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй
	2020	тийм	тийм	үгүй	үгүй	тийм	үгүй	үгүй
	2021	тийм	тийм	үгүй	үгүй	тийм	тийм	үгүй
БГД	2016	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
	2017	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	тийм
	2018	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	тийм
	2019	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	тийм
	2020	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
	2021	үгүй	тийм	үгүй	үгүй	үгүй	үгүй	тийм

[illegible]

Орон нутгийн онцлогт тохирсон арга хэмжээнд олгосон зээлийн мэдээлэл

/сая.төг/

№	Дүүрэг	Олгогдсон Он.сар.өдөр	Хугацаа /сар/	Дэмжигдсэн дүн	Эргэн төлөгдөх дүн	Үйл ажиллагааны чиглэл, зориулалт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Төлөгдсөн дүн	Үлдэгдэл Авлага	Зээлийн төлөв
1	БГД	11/6/2018	48	100.0	100.0	мах боловсруулах	-	26.0	7.0	67.0	-	33.0	67.0	Хэвийн
2		11/6/2018	48	100.0	100.0	талх, нарийн боов	-	13.2	20.9	65.9	-	34.1	65.9	Хэвийн
3		11/6/2018	48	97.0	97.0	Модон урлал	-	10.0	17.6	69.4	-	27.6	69.4	Хэвийн
		Нийт		297.0	297.0		-	49.2	45.5	202.3	-	94.7	202.3	
1	БЗД	11/28/2018	36	100.0	100.0	Газар тариалан /хүлэмж/	-	23.3	12.0	3.5	0.5	39.3	60.7	Хугацаа хэтэрсэн
2		11/28/2018	36	100.0	100.0	хүнсний үйлдвэрлэл /махан бүтээгдэхүүн/	-	26.7	20.0	53.3	-	100.0	-	Хугацаа хэтэрсэн
3		11/28/2018	36	20.0	20.0	Газар тариалан	-	2.7	-	-	-	2.7	17.3	Хугацаа хэтэрсэн
4		11/28/2018	36	100.0	100.0	Мал аж ахуй /үнээний ферм/	-	26.7	20.0	49.3	-	96.0	4.0	Хугацаа хэтэрсэн
5		11/28/2018	36	50.0	50.0	Хөдөө аж ахуй /Жимс жимсгэнэ/	-	13.4	10.0	26.6	-	50.0	-	Хугацаа хэтэрсэн
6		11/28/2018	36	80.0	80.0	оёдол	-	21.3	6.6	26.5	-	54.4	25.6	Хугацаа хэтэрсэн
7		11/28/2018	36	100.0	100.0	хүнсний үйлдвэрлэл /амтат төмс/	-	4.5	-	-	10.0	14.5	85.5	Хугацаа хэтэрсэн
8		11/28/2018	36	100.0	100.0	Нийтийн хоол үйлдвэрлэл	-	26.7	6.7	-	-	33.3	66.7	Хугацаа хэтэрсэн
9		11/28/2018	36	100.0	100.0	Нийтийн хоол үйлдвэрлэл	-	26.7	6.7	5.3	1.0	39.7	60.3	Хугацаа хэтэрсэн
10		11/28/2018	36	100.0	100.0	Газар тариалан /хүлэмж/	-	26.7	16.7	10.0	-	53.3	46.7	Хугацаа хэтэрсэн
11		11/28/2018	36	100.0	100.0	Авто засварын засвар үйлчилгээ	-	10.0	10.0	-	-	20.0	80.0	Хугацаа хэтэрсэн
12		11/28/2018	36	50.0	50.0	Оёдол	-	9.7	9.7	30.6	-	50.0	-	Хугацаа хэтэрсэн
13		12/23/2019	36	20.0	20.0	Үйл ажиллагаагаа өргөтгөх	-	-	6.7	6.7	1.7	15.1	4.9	Хэвийн
14		12/24/2019	36	20.0	20.0	Үйл ажиллагаагаа өргөтгөх	-	-	6.2	0.6	-	6.7	13.3	Хэвийн
15		12/25/2019	36	20.0	20.0	Үйл ажиллагаагаа өргөтгөх	-	-	5.6	2.2	-	7.8	12.2	Хэвийн
16		12/26/2019	36	20.0	20.0	Үйл ажиллагаагаа өргөтгөх	-	-	5.0	0.4	0.6	6.0	14.0	Хэвийн
		Нийт		1,080.0	1,080.0	-	-	218.3	141.8	215.1	13.8	589.0	491.0	
1	БНД	12/17/2018	42	50.0	50.0	эсгий, эсгий эдлэл	-	-	1.0	-	10.0	11.0	39.0	Хэвийн

2		12/17/2018	42	50.0	50.0	цэвэр усны үйлдвэрлэл	-	-	3.0	16.0	-	19.0	31.0	Хэвийн
				100.0	100.0	-	-	-	4.0	16.0	10.0	30.0	70.0	
1	СБД	12/25/2019	36	20.0	20.0	мах худалдаа	-	-	1.6	-	-	1.6	18.4	
2		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	6.7	5.6	3.4	15.7	4.3	
3		12/25/2019	36	20.0	20.0	худалдаа	-	-	2.2	3.4	1.7	7.3	12.7	
4		12/25/2019	36	20.0	20.0	арт алхам	-	-	6.7	5.6	1.7	14.0	6.0	
5		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	20.0	
6		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	20.0	
7		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	0.6	-	-	0.6	19.4	
8		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	-	-	-	-	20.0	
9		12/25/2019	36	20.0	20.0	үйлдвэрлэл	-	-	3.4	3.9	2.8	10.1	9.9	
		Нийт		180.0	180.0	-	-	-	21.2	18.5	9.5	49.2	130.8	
1	СХД	11/1/2018	36	20.0	20.0		-	-	1.0	-	-	1.0	19.0	Хугацаа хэтэрсэн
2		11/1/2018	36	55.0	55.0		-	1.9	1.0	1.0	3.0	6.9	48.1	Хугацаа хэтэрсэн
3		11/1/2018	36	25.0	25.0		-	-	2.0	1.0	-	3.0	22.0	Хугацаа хэтэрсэн
4		11/1/2018	36	100.0	100.0		-	5.0	-	10.0	9.0	24.0	76.0	Хугацаа хэтэрсэн
		Нийт		200.0	200.0		-	6.9	4.0	12.0	12.0	34.9	165.1	
1	ЧД	12/28/2018	36	100.0		өнгөт хавтан үйлдвэрлэл	24.5	-	7.0	68.5	-	100.0	-	
		Нийт		100.0	-	-	24.5	-	7.0	68.5	-	100.0	-	